МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН
ТУШААЛ

2026 оны 04 сарын 06 өдөр Дугаар А/93 Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Иргэний нисэхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2026 оны "Журам батлах тухай" 76 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний төлөвлөгөө 2026-2028"-г хавсралт ёсоор баталсугай.

2."Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний төлөвлөгөө 2026-2028"-ын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөлийн гишүүдэд даалгасугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Х.Оюунтуяа)-т үүрэг болгосугай.

САЙД Б.ДЭЛГЭРСАЙХАН

1429830235

Зам, тээврийн сайдын 2026 оны
04 дугаар сарын 06-ны өдрийн
А/93 дугаар тушаалын хавсралт

ИРГЭНИЙ НИСЭХИЙН
АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮНДЭСНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ
2026-2028

НЭГ. ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН МЭДЭГДЭЛ

1.1. Өргөн уудам газар нутагтай, далайд гарцгүй Монгол Улсын хувьд агаарын тээвэр нь эдийн засгийн хөгжлийн чухал ач холбогдолтой стратегийн салбар мөн. Монгол Улсад олон улсын стандарт шаардлагад нийцэх агаарын тээврийн салбарыг хөгжүүлэх нь биднийг дэлхийн хөгжилтэй холбох гарц болж, олон нийтийн тус салбарт итгэх итгэлийг нэмэгдүүлэх хөшүүрэг болно. Иргэний нисэхийн салбар нь үйл ажиллагааны төрөл, цар хүрээний өсөлтийг хадгалахын зэрэгцээ учирч болзошгүй эрсдэлд байнгын анхаарал хандуулж, цаг тухайд нь оновчтой арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг шаарддаг нэн хариуцлагатай салбар юм.

Сүүлийн жилүүдэд тус салбарт технологийн дэвшлээр хурдацтай ахиц шинэчлэлтүүд бий болж, эдийн засгийн статистик үзүүлэлтүүд үлэмж өсөлттэй байна. Монгол Улсад агаарын тээвэр аюулгүй, үр ашигтай, тогтвортой, хүртээмжтэй байдлаар өсөн хөгжих нь нэн чухал бөгөөд бид иргэний нисэхийн хяналт зохицуулалтын чадавхыг Олон улсын иргэний нисэхийн байгууллагын стандарт, зөвлөмжид нийцүүлэн бэхжүүлэхийг нэн тэргүүнд зорьж байна. Монгол Улсад олон улсын стандарт шаардлагад нийцэх агаарын навигацийн үйлчилгээ, аэродром, нисэх буудлын дэд бүтцийг өргөжүүлж, аюулгүй байдлын удирдлагын тогтолцоогоор баталгаажсан иргэний нисэхийн тогтолцоог мэргэшсэн хүний нөөц, санхүүгийн нөөцийн дэмжлэгтэйгээр хөгжүүлэх шаардлагатай.

1.2. Монгол Улс нь Олон улсын иргэний нисэхийн байгууллагын аюулгүй, үр ашигтай, байгаль орчинд ээлтэй иргэний нисэхийн тогтолцоог бий болгох тухай алсын харааг хүлээн зөвшөөрч, Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенцын хэлэлцэн тохиролцогч орны хувьд хүлээсэн үүргийн дагуу дэлхийн болон бүс нутгийн иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангах стратеги, зорилтуудыг үр дүнтэй хэрэгжүүлэн, салбарын үйл ажиллагаанд оролцогч талуудын хамтын ажиллагааг хангуулна.

Монгол Улсын Засгийн газар нь ОУИНБ-аас дэвшүүлж буй *"2030 он гэхэд иргэний агаарын тээвэрт агаарын хөлгийн осол гаргахгүй байх"* алсын хараа болон *"Олон улсад нисэхийн аюулгүй байдлын гүйцэтгэлийг тасралтгүй сайжруулж, Монгол Улс, Ази, Номхон далайн бүс хоорондох агаарын тээврийн салбарын хамтын ажиллагааг дэмжих замаар салбарын тогтвортой хөгжлийг дэмжих"* эрхэм зорилгыг хэрэгжүүлнэ.

1.3. "Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний төлөвлөгөө 2026-2028" баримт бичиг нь нислэгийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэл болон салбарын хяналт зохицуулалтын байгууллага болох Иргэний нисэхийн ерөнхий газрын үйл ажиллагаанд тулгарч буй сорилтыг бууруулах чиглэлээр Монгол Улсын баримтлах стратеги, зорилтыг тодорхойлох бөгөөд иргэний нисэхийн аюулгүй

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сайд, Төрийн нарийн бичгийн
дарга 26 А/93 дугаар тушаал

байдлыг тасралтгүй сайжруулан, бэхжүүлэх зорилготой. Энэхүү баримт бичиг нь Монгол Улсын иргэний нисэхийн аюулгүй байдлын журмыг хэрэгжүүлэхэд шууд дэмжлэг үзүүлнэ.

1.4. "Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний төлөвлөгөө 2026-2028" баримт бичигт Монгол Улсын газар зүй, уур амьсгал, салбарын дэд бүтцийн онцлогоос үүсэж буй иргэний нисэхийн үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах, иргэний нисэхийн аюулгүй байдлыг тасралтгүй сайжруулах зорилгоор нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх шаардлагатай аюулгүй байдлын зорилго, зорилтод уялдсан арга хэмжээг тусган батлав.

1.5. Монгол Улсын иргэний нисэхийн аюулгүй байдлын журмын дагуу 2026-2028 он хүртэл иргэний нисэхийн аюулгүй байдлын дараах 6 зорилгыг хэрэгжүүлнэ. Үүнд:

1) Улсын хэмжээнд нислэгийн үйл ажиллагааны аюулгүй байдлын өндөр эрсдэлийг тогтвортойгоор бууруулах;
2) Иргэний нисэхийн хяналт, зохицуулалтын болон агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны чадамжийг бэхжүүлэх;
3) Дээрх журам болон аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог үр дүнтэй хэрэгжүүлж, хэрэгжилтэд байнгын хяналт тавих;
4) Нисэхийн аюулгүй байдлыг дээшлүүлэхийн тулд дэлхийн болон бүс нутгийн хэмжээнд хамтын ажиллагааг өргөжүүлж, бэхжүүлэх;
5) Нисэхийн оролцогч талуудыг хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдэд татан оролцуулж, хамтын ажиллагааг дэмжих, аюулгүй байдлын мэдээлэл дамжуулах тогтолцоог бий болгох;
6) Нислэгийн аюулгүй байдлыг хангахад шаардлагатай зохих дэд бүтэц бий болсон эсэхийг бататгаж, салбарын хэмжээнд хэрэгжих төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах.

1.6. Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Зам, тээврийн яамнаас иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангуулах зорилгоор байгуулсан Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөл нь энэхүү баримт бичгийг хэрэгжүүлнэ. Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөл нь тус төлөвлөгөөнд тусгагдсан аюулгүй байдлыг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлэх жил бүрийн төлөвлөлтийг хэлэлцэн, зөвлөлийн хэрэгжүүлэх арга хэмжээний жилийн төлөвлөгөө болгон баталж, хэрэгжилтийг хангана.

1.7. Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөлийн гишүүн байгууллагууд нь аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны хүрээнд аюулгүй байдлын гүйцэтгэл, аюулгүй байдлыг сайжруулах арга хэмжээний хэрэгжилтийг хянаж, зөвлөлийн хурлаар эргэн тайлагнах замаар хамтын ажиллагаа болон хариуцлагын тогтолцоог бүрдүүлнэ.

1.8. Иргэний нисэхийн салбарын оролцогч байгууллагууд болон ажилтан бүр энэхүү төлөвлөгөөтэй танилцаж, удирдамж болгон ажиллахыг үүрэг болгохын зэрэгцээ тус баримт бичгийг нисэхийн аюулгүй байдлын лавлагаа, баримтлах чиглэлээ болгон ашиглахыг уриалж байна.

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сайд Төрийн захиргаа бичгийн
дарын 26 1/93 үйлчлэгч гүйцэтгэх

ХОЁР. ТАНИЛЦУУЛГА

2.1. Нийтлэг үндэслэл

2.1.1. “Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний төлөвлөгөө 2026-2028” (цаашид National Aviation Safety Plan “NASP 2026-2028” гэх) баримт бичгийг Олон улсын иргэний нисэхийн байгууллага (цаашид “ОУИНБ” гэх)-ын “Дэлхийн нисэхийн аюулгүй байдлын төлөвлөгөө 2026-2028” болон Ази, Номхон далайн бүс нутгийн нисэхийн аюулгүй байдлын бүлгээс баталсан “Ази, Номхон далайн бүс нутгийн аюулгүй байдлын төлөвлөгөө 2026-2028”-нд тус тус үндэслэн боловсруулав.

2.1.2. Монгол Улс нь NASP 2026-2028 баримт бичгийг ОУИНБ-ын баримт бичиг “DOC 10161. Дэлхийн нисэхийн аюулгүй байдлын замын зураглал” болон “DOC 10162. Бүс нутгийн болон нисэхийн аюулгүй байдлын үндэсний төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах заавар”-т тус тус нийцүүлэн боловсруулсан болно.

2.2. “Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний төлөвлөгөө 2026-2028” баримт бичгийг боловсруулах үндэслэл

2.2.1. ОУИНБ нь Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенц (цаашид “Конвенц” гэх)-ын “Хавсралт 19. Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо” стандарт болон 2023 оны APRAST/23 хурлын 23/5 дугаар шийдвэрээр хэлэлцэн тохиролцогч улс орнууд “Дэлхийн нисэхийн аюулгүй байдлын төлөвлөгөө 2026-2028”, “Ази, Номхон далайн бүс нутгийн аюулгүй байдлын төлөвлөгөө 2026-2028” болон тухайн улсын Иргэний нисэхийн аюулгүй байдлын журам (цаашид “SSP” гэх)-д нийцсэн Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлэх шаардлагыг тогтоосон.

ОУИНБ-ын Ази, Номхон далайн бүсийн төв нь 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн аюулгүй байдлын 15 дугаар хурлын 15/04 дүгээр хурлын шийдвэрээр “Ази, Номхон далайн бүс нутгийн аюулгүй байдлын төлөвлөгөө 2026-2028”-г хэлэлцэн баталсан.

2.2.2. Энэхүү төлөвлөгөөнд SSP-ээр тогтоосон Монгол Улсын иргэний нисэхийн аюулгүй байдлын бодлого, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, аюулгүй байдлыг сайжруулах арга хэмжээ (SEIs)-г тусган баталгаажуулна.

2.2.3. NASP 2026-2028-ыг хэрэгжүүлснээр иргэний нисэхийн хяналт зохицуулалтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, эрсдэлд суурилсан аргачлалаар аюулгүй байдлыг тасралтгүй сайжруулах, салбарын хамтын ажиллагаа, үйл ажиллагааны уялдаа холбоог дэмжих чухал ач холбогдолтой.

2.3. “Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний төлөвлөгөө 2026-2028” баримт бичгийн бүтэц

2.3.1. NASP 2026-2028 нь дараах 5 бүлгээс бүрдэнэ. Үүнд:

- Бүлэг 1.Зам, тээврийн сайдын мэдэгдэл;
- Бүлэг 2.Танилцуулга;
- Бүлэг 3.Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний төлөвлөгөөний зорилго;
- Бүлэг 4.Монгол Улсын иргэний нисэхийн үйл ажиллагааны аюулгүй байдлын асуудлууд;
- Бүлэг 5.Монгол Улсын иргэний нисэхийн аюулгүй байдлын удирдлагын стратеги чиглэл;
- Бүлэг 6.Төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих.

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Баримт бичгийн
Дэвсгэр 26 А/63

2.4. Монгол Улсын Иргэний нисэхийн аюулгүй байдлын журам (SSP) болон Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний төлөвлөгөө (NASP)-ний уялдаа холбоо

2.4.1. Монгол Улс нь SSP баримт бичгээр иргэний нисэхийн аюулгүй байдлын бодлого, зорилт, аюулгүй байдлын эрсдэлийн удирдлага, аюулгүй байдлын баталгаажуулалт, аюулгүй байдлын сургалт, сурталчилгааны шаардлагад нийцсэн иргэний нисэхийн аюулгүй байдлын хяналт зохицуулалтыг бий болгоно. Мөн иргэний нисэхийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог дэмжих эрх зүйн зохицуулалт болон үйл явцын дэлгэрэнгүй мэдээллийг олон нийтэд танилцуулна.

2.4.2. Монгол Улс нь SSP-ээр тогтоосон Монгол Улсын иргэний нисэхийн аюулгүй байдлын бодлого, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, аюулгүй байдлыг сайжруулах арга хэмжээг төлөвлөн NASP-д тусган баталгаажуулж, SSP-ийн хэрэгжилтийг хангуулна.

2.4.3. NASP 2026-2028 баримт бичиг нь “Дэлхийн нисэхийн аюулгүй байдлын төлөвлөгөө 2026-2028”, “Ази, Номхон далайн бүс нутгийн аюулгүй байдлын төлөвлөгөө 2026-2028” болон ОУИНБ-ын аюулгүй байдлын журмын хэрэгжилтийн үнэлгээнд дурдсан аюулгүй байдлын өгөгдөлд дүн шинжилгээ хийх чадавх хангалтгүй байгаа нөхцөлд хамаарах эрсдэлүүдэд үндэслэн боловсруулагдсан болно.

2.4.4. NASP 2026-2028-д тусгагдсан аюулгүй байдлыг сайжруулах арга хэмжээ нь нислэгийн үйл ажиллагааны аюулгүй байдлын эрсдэлүүдийг олон улсын зөвлөмжийн дагуу тогтвортой бууруулах, Иргэний нисэхийн ерөнхий газар (цаашид “ИНЕГ” гэх)-ын хяналт зохицуулалтын үйл ажиллагааны сорилтуудыг шийдвэрлэхэд чиглэсэн.

2.4.5. Монгол Улсын иргэний нисэхийн дүрмээр гэрчилгээжин, үйл ажиллагаа явуулж буй салбарын оролцогч талууд “ИНД-100. Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо” дүрмийн шаардлагад нийцсэн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо (цаашид Safety management system “SMS” гэх)-г хэрэгжүүлж, SSP болон NASP-ын хэрэгжилтийг хангуулна.

2.5. Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний төлөвлөгөө (NASP)-г хэрэгжүүлэх үндсэн оролцогч талууд

2.5.1. Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөлийн гишүүн байгууллагууд иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангуулах үүрэгтэй.

2.5.2. Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөл нь дараах байгууллагуудын удирдах албан тушаалтнаас бүрдсэн бүрэлдэхүүнтэй байна:

2.5.2.1.Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;
2.5.2.2.Батлан хамгаалахын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;
2.5.2.3.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;
2.5.2.4.Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба;
2.5.2.5.Иргэний нисэхийн ерөнхий газар;

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ

2.5.2.6.Онцгой байдлын ерөнхий газар;
2.5.2.7.Ус цаг уур, орчны шинжилгээний газар;
2.5.2.8.Зэвсэгт хүчний жанжин штаб;
2.5.2.9.Агаарын цэргийн командлал;
2.5.2.10.иргэний нисэхийн дүрмээр гэрчилгээжсэн үйлчилгээ эрхлэгч байгууллагууд.

2.5.3. Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөл нь энэхүү төлөвлөгөөний Хавсралт 3, Хавсралт 4, Хавсралт 5-ын дагуу хэрэгжилтийг хангах үүрэгтэй.

2.6. Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний төлөвлөгөө (NASP)-г боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих

2.6.1. Олон улсын иргэний нисэхийн байгууллагын үүрэг

2.6.1.1.ОУИНБ нь дэлхийн нисэхийн аюулгүй байдлын төлөвлөгөөг дэлхий даяар болон бүс нутгийн түвшинд хэрэгжүүлэх, хяналт тавих үүрэгтэй бөгөөд энэхүү баримт бичгээр дамжуулан иргэний нисэхийн аюулгүй байдлыг сайжруулах стратегийг олон улсад хэрэгжүүлдэг. Конвенцын хэлэлцэн тохиролцогч улс орнууд нь дэлхийн нисэхийн аюулгүй байдлын төлөвлөгөөнд тусгагдсан зорилго, зорилтуудыг аюулгүй байдлыг сайжруулах арга хэмжээ болон "DOC 10161. Дэлхийн нисэхийн аюулгүй байдлын замын зураглал"-д тусгагдсан дэлхийн иргэний нисэхийн салбарын өндөр эрсдэлтэй ангилалд хамаарах тохиолдлууд (High risk categories of occurrences - HRCs)-ыг ашиглан хэрэгжүүлнэ.

2.6.1.2.ОУИНБ нь Конвенцын хэлэлцэн тохиролцогч улс орнуудын дунд нээлттэй мэдээлэл, салбарын сайн туршлага хуваалцахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Ази, Номхон далайн бүс нутгийн нисэхийн аюулгүй байдлын бүлэг болон бүс нутгийн нисэхийн аюулгүй байдлын багийн үйл ажиллагааг зохицуулж ажилладаг.

2.6.2. ОУИНБ-ын Ази, Номхон далайн бүс нутгийн нисэхийн аюулгүй байдлын бүлгийн үүрэг

2.6.2.1.ОУИНБ нь дэлхийн иргэний нисэхийн аюулгүй байдлыг сайжруулж, хамтын ажиллагааг дэмжих зорилгоор бүс нутгийн салбар төвийг байгуулсан. Монгол Улс нь ОУИНБ-ын Ази, Номхон далайн бүсэд хамаарна. ОУИНБ-ын бүс нутгийн салбар төв тус бүр тухайн бүсэд баримтлах аюулгүй байдлын бодлого, зорилтыг тодорхойлсон бүс нутгийн иргэний нисэхийн аюулгүй байдлын төлөвлөгөөг баталдаг.

2.6.2.2.Ази, Номхон далайн бүс нутгийн аюулгүй байдлын төлөвлөгөөг дэлхийн нисэхийн аюулгүй байдлын төлөвлөгөөнд үндэслэн боловсруулдаг ба тухайн бүс нутгийн салбарын онцлог, бүртгэгдсэн аюулгүй байдлын өндөр эрсдэлийг бууруулахад чиглэнэ. Ази, Номхон далайн бүс нутгийн аюулгүй байдлын төлөвлөгөөний боловсруулалт, хэрэгжилтэд тус бүс нутгийн нисэхийн аюулгүй байдлын бүлэг хяналт тавин ажилладаг. Ази, Номхон далайн бүс нутгийн нисэхийн аюулгүй байдлын бүлгийн үйл ажиллагааг тус бүсийн аюулгүй байдлын техникийн баг дэмжин ажилладаг.

2.6.3. Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Зам, тээврийн яамны үүрэг

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ

2.6.3.1.Зам, тээврийн яам (цаашид "ЗТЯ" гэх) нь NASP-ыг батлах, бодлогын баримт бичгийг SSP болон NASP-д нийцүүлэн боловсруулахад хяналт тавих, эдгээр баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах үүрэгтэй.

2.6.3.2.ЗТЯ нь иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөлийн хурлыг ИНЕГ-тай хамтран зохион байгуулж, SSP-ийн хэрэгжилтийг хангуулна.

2.6.4. Иргэний нисэхийн ерөнхий газрын үүрэг

2.6.4.1.ИНЕГ нь SSP болон NASP-ын төслийг боловсруулан, хэрэгжилтийг хангуулж, хяналт тавьж ажиллана.

2.6.4.2.Эдгээр баримт бичгийг боловсруулахад Монгол Улсын агаарын тээврийн үйл ажиллагаанд тулгарч буй сорилт, шинээр үүсэж буй иргэний нисэхийн аюулгүй байдлын асуудал, салбарыг хөгжүүлэх стратегийн тэргүүлэх чиглэлийг харгалзан үзсэн байна. Мөн дэлхийн нисэхийн аюулгүй байдлын төлөвлөгөө, Ази, Номхон далайн бүс нутгийн аюулгүй байдлын төлөвлөгөөнд нийцүүлэн, салбарын үйл ажиллагаан дахь иргэний нисэхийн салбарын өндөр эрсдэлтэй ангилалд хамаарах тохиолдлууд (HRCs)-ыг нэн тэргүүнд шийдвэрлэхэд шаардлагатай арга хэмжээг тусгана.

2.6.4.3.ИНЕГ нь Дэлхийн нисэхийн аюулгүй байдлын төлөвлөгөө, Ази, Номхон далайн бүс нутгийн аюулгүй байдлын төлөвлөгөө, SSP-ийн нэмэлт, өөрчлөлттэй уялдуулан NASP-д 3 жил тутам холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулна.

2.6.4.4.Дээрх хугацаанаас өмнө иргэний нисэхийн үйл ажиллагаатай холбоотой аюулгүй байдлын ноцтой эрсдэл илэрсэн тохиолдолд, эрсдэлийг бууруулах арга хэмжээг шуурхай авч, NASP-ыг хугацаанаас нь өмнө шинэчилж болно.

2.6.4.5.ОУИНБ-ын болон Ази, Номхон далайн бүсийн төвөөс зохион байгуулж буй иргэний нисэхийн аюулгүй байдлын хурал, зөвлөгөөн, ажлын хэсгийн уулзалт, сургалтад хамрагдаж, бүс нутгийн аюулгүй байдлын тэргүүлэх чиглэл, аюулгүй байдлын зорилго, зорилтыг боловсруулахад идэвхтэй хамтран ажиллана.

2.6.5. Агаарын тээврийн салбарын оролцогч талуудын үүрэг

2.6.5.1.Монгол Улсын агаарын тээврийн салбарын оролцогч нийт байгууллагууд аюулгүй байдлын мэдээллийг ИНЕГ-т болон хоорондоо нээлттэй, шуурхай солилцож, нисэхийн аюулгүй байдлын хяналт зохицуулалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.

2.6.5.2.Дээрх байгууллагууд нь SSP-ээр батлагдсан Монгол Улсын иргэний нисэхийн аюулгүй байдлын зорилго, зорилт, NASP-д тусгагдсан аюулгүй байдлыг сайжруулах арга хэмжээ, улсын хэмжээнд мөрдөх аюулгүй байдлын гүйцэтгэлийн үзүүлэлтүүд зэрэгт нийцүүлэн, тухайн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирох аюулгүй байдлын гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийг тогтоох, тогтмол хянах, аюулгүй байдлын баталгаажуулалтыг гүйцэтгэнэ.

2.6.5.3.Агаарын тээврийн салбарын оролцогч нийт байгууллагууд нь өөрийн байгууллагад мөрдөх SMS-ын бодлого, зорилт болон аюулгүй байдлын

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Дарын 26 А/93

гүйцэтгэлийн үзүүлэлтийг боловсруулахдаа уялдаа холбоотой, нэгдсэн хандлагыг баримтлан ажиллана.

2.6.5.4.Иргэний нисэхийн аюулгүй байдлыг салбарын хэмжээнд бүх түвшинд хангуулах зорилгоор аюулгүй байдлын эрсдэлийн удирдлагын тогтолцоог үйл ажиллагаандаа бүрэн нэвтрүүлж, аюулгүй байдлын мэдээллийг нээлттэй, шуурхай дамжуулах, эрсдэлийг бууруулах арга хэмжээг нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх, аюулгүй байдлын эерэг соёл бүхий тогтолцоог бүрдүүлнэ.

2.7. Дэлхий болон Ази, Номхон далайн бүс нутгийн нисэхийн аюулгүй байдлын эрсдэл болон зорилго, зорилт

2.7.1. Дэлхий дахинд тулгарч буй нисэхийн аюулгүй байдлын эрсдэлүүд

2.7.1.1.ОУИНБ нь аюулгүй байдлын өгөгдөлд тулгуурлан олон улсын иргэний нисэхийн салбарт тулгарч буй сорилт болон тэргүүлэх чиглэлүүдийг дэлхийн нисэхийн аюулгүй байдлын төлөвлөгөөнд тусган тодорхойлдог. Эдгээр сорилтуудаас үүсэж буй аюулгүй байдлын эрсдэлийг бууруулахын тулд дэлхийн хэмжээнд хэрэгжүүлэх аюулгүй байдлыг сайжруулах арга хэмжээг боловсруулж, ач холбогдлоор нь эрэмбэлэн тогтоож байна.

2.7.1.2.Монгол Улс нь иргэний нисэхийн аюулгүй байдлын асуудлуудыг тодорхойлохдоо дэлхийн нисэхийн аюулгүй байдлын төлөвлөгөөнд тусгасан эрсдэл, сорилт, аюулгүй байдлыг сайжруулах арга хэмжээнд нийцүүлэн тогтооно.

2.7.1.3."Дэлхийн нисэхийн аюулгүй байдлын төлөвлөгөө 2026-2028" нь дэлхийн хэмжээнд иргэний нисэхийн үйл ажиллагаанд хэрэгжүүлэх аюулгүй байдлын дараах зорилго, зорилтыг тогтоосон. Үүнд:

- Зорилго 1. Нислэгийн үйл ажиллагааны аюулгүй байдлын эрсдэлүүдийг тогтвортойгоор бууруулах.
  - Зорилт 1.1. Дэлхий даяарх агаарын хөлгийн ослын түвшинг бууруулсан чиг хандлагыг хадгалах.
- Зорилго 2. Нисэхийн аюулгүй байдлын хяналт зохицуулалтын байгууллагын чадавхыг бэхжүүлэх:
  - Зорилт 2.1. Улс орнууд нисэхийн аюулгүй байдлын хяналт зохицуулалтын байгууллагын чадавхыг сайжруулах хангалттай хэмжээний санхүүгийн нөөцтэй байхад анхаарах;
  - Зорилт 2.2. Нисэхийн аюулгүй байдлын чухал элемент (Critical Element - CE) "CE-4. Иргэний нисэхийн хяналтын байцаагч, шинжээчийг мэргэшүүлэх сургалт, дадлага"-ын үр дүнтэй хэрэгжилтийн үзүүлэлт (Effective implementation - EI) оноог нэмэгдүүлэх. Ялангуяа агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах шинжээч болон аэродром, газрын туслах хэрэгслийн аюулгүй байдлын хяналтын байцаагчдыг бэлтгэх;
  - Зорилт 2.3. Аэродром, газрын туслах хэрэгсэлийн хяналтын чиглэлээр "CE-8. Аюулгүй байдлын талаар авч буй залруулах арга хэмжээ"-ний үр дүнтэй хэрэгжилтийн оноо (EI)-г нэмэгдүүлэх.
- Зорилго 3. Үр дүнтэй SSP-г боловсруулж, хэрэгжүүлэн, удирдах:
  - Зорилт 3.1. Улс орнууд SSP-ийн хэрэгжилтийн үнэлгээнд анхаарах.
- Зорилго 4. Аюулгүй байдалтай холбоотой хамтын ажиллагааг бүс нутаг болон үндэсний түвшинд бэхжүүлэх:

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сайд, Төрийн нарийн бичгийн
дарга 26 А/53 гүйцэтгэх үүрэг бүхий

- Зорилт 4.1. Бүс нутгийн хэмжээнд тусламж үзүүлэх аргачлал, стратегид төвлөрөх.

• Зорилго 5. Иргэний нисэхийн аюулгүй байдлын төлөвлөлтийг бэхжүүлэх. Бүс, нутгийн аюулгүй байдлын төлөвлөгөө болон NASP-ыг боловсруулж, хэрэгжүүлэх;
• Зорилго 6. Салбарын төсөл, хөтөлбөрүүдийн хэрэглээг өргөжүүлэх.

2.7.1.4.Дэлхийн нисэхийн аюулгүй байдлын төлөвлөгөөнд дэлхийн хэмжээнд анхаарах аюулгүй байдлын эрсдэлийг дараах 2 төрөлд хуваан ангилдаг. Үүнд:

1) Нислэгийн үйл ажиллагааны аюулгүй байдлын эрсдэл (Operational safety risk);
2) Иргэний нисэхийн хяналт зохицуулалтын байгууллагын сорилтууд.

2.7.1.5.Дэлхийн нисэхийн аюулгүй байдлын төлөвлөгөөнд дэлхий даяар бүртгэгдсэн хүний амь нас эндсэн агаарын хөлгийн ослын тоо, амь нас эндээгүй агаарын хөлгийн осол болон ноцтой зөрчлийн тоонд үндэслэн дараах 8 төрлийн дэлхийн иргэний нисэхийн салбарын өндөр эрсдэл (HRCs)-ийг тогтоосон байна. Үүнд:

1) Хяналттай нислэг газрын гадаргууг мөргөх *(Controlled Flight into Terrain – CFIT);*
2) Нислэгийн үеэр удирдлагын жолоо алдагдах *(Loss of Control – In Flight - LOC-I)*;
3) Агаарын хөлгүүд агаарт мөргөлдөх *(Mid-Air Collision – MAC)*;
4) Хөөрч, буух зурвасаас гарах *(Runway Excursion – RE)*;
5) Хөөрч, буух зурвас руу зөвшөөрөлгүй нэвтрэх *(Runway Incursion – RI)*;
6) Агаарын хөлгийн хөөрч, буух зурвас дахь хэвийн бус буулт - Агаарын хөлөг хатуу буух, агаарын хөлөг сүүл хэсгээрээ газарт хүрэх *(Abnormal Runway Contact - ARC, including Hard Landing and Tail Strike Landing)*;
7) Нислэгийн үед агаарын хөлөг сэгсрэлтэнд орох *(Turbulence encounter – TURB)*;
8) Хүчний төхөөрөмжөөс бусад систем, эд ангийн дутагдал, эсхүл эвдрэл (System/component failure or malfunction *(non-powerplant – SCF-NP)*.

2.7.1.6.Дэлхийн нисэхийн аюулгүй байдлын төлөвлөгөөгөөр улс орнууд аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх, аюулгүй байдлын өгөгдөлд дүн шинжилгээ хийхдээ эдгээр 8 төрлийн дэлхийн иргэний нисэхийн салбарын өндөр эрсдэл (HRCs)-ийг харгалзан үзэхийг шаардсан. Мөн эдгээр агаарын хөлгийн осол, зөрчлийн тохиолдол үүсэхэд нөлөөлж болзошгүй хүчин зүйлд нарийвчилсан дүн шинжилгээ хийхийг шаарддаг байна.

2.7.1.7.Дэлхийн нисэхийн аюулгүй байдлын төлөвлөгөөнд дэлхий дахинд тулгарч буй иргэний нисэхийн хяналт зохицуулалтын байгууллагын дараах 2 төрлийн нийтлэг сорилтуудыг бууруулахаар тусгасан. Үүнд:

1) Үр дүнтэй иргэний нисэхийн хяналт зохицуулалтын тогтолцоо;
2) Аюулгүй байдлын эрсдэлд суурилсан аргачлалаар аюулгүй байдлын гүйцэтгэлийг хэмжиж, хянах үр нөлөөтэй SSP-ийн хэрэгжилт.

2.7.2.Ази, Номхон далайн бүс нутгийн хэмжээнд тулгарч буй иргэний нисэхийн аюулгүй байдлын эрсдэлүүд

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ

2.7.2.1.Ази, Номхон далайн бүсийн иргэний нисэхийн аюулгүй байдлын стратеги нь дараах 2 зарчимд үндэслэн боловсруулагдсан. Үүнд:

1) Одоогийн бүс нутгийн платформуудыг бэхжүүлж, үр нөлөөтэй иргэний нисэхийн аюулгүй байдлын хяналт зохицуулалтын чадавхыг бий болгох;
2) Нислэгийн үйл ажиллагааны аюулгүй байдлын эрсдэлүүдийг үр дүнтэй бууруулж, үр нөлөө бүхий аюулгүй байдлын эрсдэлийн удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх.

2.7.2.2. Ази, Номхон далайн бүс нутгийн нисэхийн аюулгүй байдлын бүлэг нь бүс нутгийн иргэний нисэхийн аюулгүй байдлын дүн шинжилгээг жил бүр хэлэлцэж, баталгаажуулдаг. Тус бүс нутагт иргэний нисэхийн аюулгүй байдлын түвшин болон улс орнуудын хяналт зохицуулалтын байгууллагын чадавх харилцан адилгүй байгаа бөгөөд ОУИНБ-ын "Нисэхийн аюулгүй байдлын хяналтын олон талт хөтөлбөр - Байнгын хяналтын аргачлал (цаашид "Universal Safety Oversight Audit Programme - Continuous Monitoring Approach - USOAP-CMA" гэх)"-ын үр дүнтэй хэрэгжилтийн үзүүлэлт (EI)-ийн оноо 2026 оны 03 дугаар сарын байдлаар 66.6%-ийн дундаж үзүүлэлттэй байна.

2.7.2.3. "Ази, Номхон далайн бүс нутгийн төлөвлөгөө 2026-2028" баримт бичгээр тус бүс нутгийн нислэгийн үйл ажиллагааны аюулгүй байдлын эрсдэлийг дараах байдлаар тогтоосон байна. Үүнд:

1) Хөөрч, буух зурвасаас гарах *(Runway Excursion – RE)*;
2) Агаарын хөлгүүд агаарт мөргөлдөх *(Mid-Air Collision – MAC)*;
3) Хяналттай нислэг газрын гадаргууг мөргөх *(Controlled Flight into Terrain – CFIT);*
4) Нислэгийн үеэр удирдлагын жолоо алдагдах *(Loss of Control – In Flight - LOC-I)*;
5) Хөөрч, буух зурвас руу зөвшөөрөлгүй нэвтрэх *(Runway Incursion – RI)*;
6) Хүчний төхөөрөмжөөс бусад систем, эд ангийн дутагдал, эсхүл эвдрэл (System/component failure or malfunction *(non-powerplant – SCF-NP)*;
7) Агаарын хөлгийн хөөрч, буух зурвас дахь хэвийн бус буулт - Агаарын хөлөг хатуу буух, агаарын хөлөг сүүл хэсгээрээ газарт хүрэх *(Abnormal Runway Contact - ARC, including Hard Landing and Tail Strike Landing)*;
8) Хүчний төхөөрөмжийн систем, эд ангийн дутагдал, эсхүл эвдрэл (System/component failure or malfunction *(powerplant – SCF-PP)*;
9) Нислэгийн үед агаарын хөлөг сэгсрэлтэнд орох *(Turbulence encounter – TURB)*.

2.7.2.4."Ази, Номхон далайн бүс нутгийн төлөвлөгөө 2026-2028" нь тус бүс нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх иргэний нисэхийн аюулгүй байдлын дараах зорилго, зорилтыг баталгаажуулсан байна. Үүнд:

Зорилго	Зорилт		Хэмжих үзүүлэлт
1. Нислэгийн үйл ажиллагааны аюулгүй байдлын эрсдэлүүдийг тогтвортойгоор бууруулах.	1.1.	2028 он гэхэд тус бүс нутгийн агаарын хөлгийн ослын түвшний 5 жилийн дундаж үзүүлэлтийг бууруулах чиг хандлагыг хадгална.	- Ослын түвшин (1 сая нислэг тутамд ногдох ослын тоо); - Хүний амь нас эрсэдсэн ослын түвшин (1 сая нислэг тутамд

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
26 А193

			ногдох хүний амь нас эрсэдсэн ослын тоо); - Хүний амь нас эрсэдсэн түвшин (1 тэрбум тээвэрсэн зорчигч тутамд ногдох хүний амь нас эрсэдсэн тоо).
	1.2.	2028 он гэхэд Ази, Номхон далайн бүс нутаг нь бүс нутгийн аюулгүй байдлын өндөр эрсдэлтэй ангилал */энэхүү баримт бичгийн 3.6.2.3-т тусгасан (R-HRC)/* түс бүрт хамаарах агаарын хөлгийн осол, ноцтой зөрчлийн түвшний 5 жилийн дундаж үзүүлэлтийг бууруулах чиг хандлагыг хадгалах.	- R-HCR-ээр ангилсан ослын түвшин; - R-HCR-ээр ангилсан ноцтой зөрчлийн түвшин; - Нийт агаарын хөлгийн осолтой харьцуулахад R-HCR-т хамаарах ослын хувь.
	1.3.	2028 он гэхэд Ази, Номхон далайн бүс нутгийн аюулгүй байдлын эрсдэлийн ангилалд хамаарах агаарын хөлгийн осол, ноцтой зөрчлийн түвшний 5 жилийн дундаж үзүүлэлтийг бууруулах чиг хандлагыг хадгалах.	- Бусад бүс нутгийн эрсдэлийн ангиллаар тооцсон ослын түвшин; - Бусад бүс нутгийн эрсдэлийн ангиллаар тооцсон ноцтой зөрчлийн түвшин; - Бусад бүс нутгийн эрсдэлийн ангиллаар тооцсон хүний амь нас эрсэдсэн ослын түвшин.
2. Улсуудын аюулгүй байдлын хяналт зохицуулалтын чадавхыг бэхжүүлэх.	2.1.	2028 он гэхэд Ази, Номхон далайн бүс нутгийн орнууд NASP-ыг батлан, хэрэгжүүлж, иргэний нисэхийн аюулгүй байдлын хяналт зохицуулалтын байгууллага (CAA)-ыг үндэсний болон олон улсын үүргээ биелүүлэхэд шаардлагатай хангалттай хэмжээний санхүүгийн нөөцөөр хангана. Мөн Ази, Номхон далайн бүс нутгийн дор хаяж 70% нь хангалттай санхүүгийн нөөцтэй байна.	ОУИНБ-ын USOAP-CMA-ын протокол асуулт (PQ) 2.0512-оор “хангалттай” үнэлгээ авсан улс орнуудын хувь.
	2.2.	2028 он гэхэд Ази, Номхон далайн бүс нутгийн бүх улс орнууд агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах (AIG) шинжээч болон аэродром, газрын туслах хэрэгсэлийн аюулгүй байдлын хяналтын чиглэл (AGA)-ээр мэргэшсэн хүний нөөцийн сургалт, дадлага (CE-4) түвшний үр дүнтэй хэрэгжилтийн оноо (EI)-г тус тус сайжруулна.	- CE-4/AIG-ийн хувьд дэлхийн суурь дундажтай тэнцүү буюу түүнээс өндөр EI оноог хангасан улс орнуудын хувь; - CE-4/AGA-ийн хувьд дэлхийн суурь дундажтай тэнцүү буюу түүнээс өндөр EI оноог хангасан улс орнуудын

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сайд Төрийн нарийн бичгийн
дарга 26 А/53 гарын үсэг

		Мөн тус бүс нутгийн бүх улс орнууд дэлхийн суурь дундаж онооноос доогуур оноотой үнэлэгдэхгүй байх үүрэг хүлээнэ.	хувь.
	2.3.	2028 он гэхэд Ази, Номхон далайн бүс нутгийн улс орнууд аэродром, газрын туслах хэрэгслийн хяналтын чиглэл (AGA)-д аюулгүй байдлын асуудлыг шийдвэрлэх (CE-8) түвшний үр дүнтэй хэрэгжилтийн оноо (EI)-г сайжруулна. Мөн бүх улс дэлхийн суурь дундаж онооноос доогуур оноотой байхгүй байх үүрэг хүлээнэ.	CE-8/AGA-ийн хувьд дэлхийн суурь дундажтай тэнцүү буюу түүнээс өндөр EI оноог хангасан улс орнуудын хувь.
	2.4.	2028 он гэхэд Ази, Номхон далайн бүс нутгийн улс орнууд дор хаяж 70 хувь нь хараат бус агаарын хөлгийн осол, ноцтой зөрчлийг шинжлэн шалгах (AAIB)-ыг байгуулсан байна.	Хараат бус агаарын хөлгийн осол, ноцтой зөрчлийг шинжлэн шалгах (AAIB)-ыг байгуулсан улс орнуудын хувь.
3. Улсын аюулгүй байдлын хөтөлбөр (SSP)-ыг баталж, хэрэгжүүлэх болон удирдах.	3.1.	2026 он гэхэд Ази, Номхон далайн бүс нутгийн бүх улс орнууд SSP-ийн хэрэгжилтийг үнэлнэ.	ОУИНБ-ын USOAP-CMA-ын online framework (OLF) системд SSP протокол асуулт (PQ)-ыг бөглөсөн хувь.
	3.2.	2028 он гэхэд Ази, Номхон далайн бүс нутгийн бүх улс орнууд SSP-ийг баталсан байна.	- SSP-ийг баталсан улс орнуудын хувь; - Аюулгүй байдлын өгөгдөл цуглуулах, дүн шинжилгээ хийх систем (Safety data processing system - SDPC)-ийг хэрэгжүүлсэн улс орнуудын хувь; - Аюулгүй байдлын өгөгдөл, мэдээллийг хамгаалах тогтолцоог бүрдүүлсэн улс орнуудын хувь.
4. Аюулгүй байдлын асуудлаар бүс нутаг болон үндэсний хамтын ажиллагааг бэхжүүлэх.	4.1.	2026 он гэхэд Ази, Номхон далайн бүс нь үр дүнтэй хэрэгжилт (EI)-ийн түвшинд үндэслэн хамгийн өндөр тэргүүлэх ач холбогдолтой аюулгүй байдлын асуудлыг шийдвэрлэхэд тусламж шаардлагатай улс орнуудыг дараах байдлаар тодорхойлно. Үүнд: • Бүлэг 1: EI < 50% • Бүлэг 2: 50% < EI < 75%	Хамгийн өндөр тэргүүлэх ач холбогдолтой аюулгүй байдлын асуудлыг шийдвэрлэхэд тусламж шаардлагатай гэж тодорхойлогдсон Ази, Номхон далайн бүсийн улс орнуудыг тус тусын бүлэгт хуваан эзлэх хувь.
	4.2.	2028 он гэхэд Ази, Номхон далайн бүсийн төв нь 4.1-т тодорхойлогдсон улс орнуудад	Хамгийн өндөр тэргүүлэх ач холбогдолтой аюулгүй

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сайд Төрийн нарийн бичгийн
дарга 26 A/53 гүйцэтгэх үүрэг түүнд

		хамгийн өндөр тэргүүлэх ач холбогдолтой аюулгүй байдлын асуудлыг шийдвэрлэхэд тусламж үзүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.	байдлын асуудлыг шийдвэрлэхэд тусламжыг хүлээн авсан Ази, Номхон далайн бүсийн улс орнуудын бүлэг тус бүрийн хувь.
	4.3.	2027 он гэхэд Ази, Номхон далайн бүсийн төв нь иргэний нисэхийн аюулгүй байдлын төлөвлөлтийн зорилгоор үйл ажиллагааны аюулгүй байдлын эрсдэл болон шинээр гарч буй асуудлуудын талаарх мэдээллийг ашиглах механизмийг тус бүс нутагт хэрэгжүүлнэ.	- ОУИНБ-ын "Operational Safety Risks & Emerging Issues" аюулгүй порталд бүртгэгдсэн тус бүс нутгийн улс орнуудын хувь; - Үйл ажиллагааны аюулгүй байдлын эрсдэл ба шинээр гарч буй асуудлуудын талаар тус порталаар дамжуулан хүлээн авсан тайлангийн тоо; - Аюулгүй порталаар дамжуулан хүлээн авсан тайланд үндэслэн RASG-APAC-аас хийсэн судалгаа эсхүл дүн шинжилгээний тоо.
	4.4.	2028 он гэхэд RASG-APAC нь RASG-ийн үйл ажиллагааг идэвхтэй манлайлан оролцож буй улс орнуудын хувийг нэмэгдүүлнэ.	- RASG-APAC-ийн үйл ажиллагааг (ажлын хэсэг, баг, даалгаварын бүлгүүд болон SEI хэрэгжилт) идэвхтэй манлайлан оролцож буй тус бүс нутгийн улс орнуудын хувь.
5. Иргэний нисэхийн аюулгүй байдлын төлөвлөлтийг бэхжүүлэх.	5.1.	2027 он гэхэд Ази, Номхон далайн бүсийн бүх улс орнууд NASP-ийн шинэчилсэн хувилбарыг нийтлэх ба "Дэлхийн нисэхийн аюулгүй байдлын төлөвлөгөө 2026-2028" болон "Ази, Номхон далайн бүс нутгийн нисэхийн аюулгүй байдлын төлөвлөгөө 2026-2028" баримт бичгийг харгалзан үзсэн байна.	- Шинэчилсэн NASP-ыг нийтэлсэн улс орнуудын хувь; - Үйлдвэрлэлийн байгууллагуудтай зөвлөлдсөний үндсэн дээр боловсруулсан NASP-ын хувь.
6. Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үнэлгээний хөтөлбөрүүд болон аюулгүй байдлын өгөгдөл хуваалцах хөтөлбөрийн хэрэглээг өргөжүүлэх.	6.1.	2028 он гэхэд Ази, Номхон далайн бүсийн бүх улс орнуудын үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд дараах хөтөлбөрийг ашиглах хэмжээг нэмэгдүүлэх чиг хандлагыг хадгалах (2025 оныг суурь жил болгон тооцсон): 1. Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үнэлгээний	- ОУИНБ-аас хүлээн зөвшөөрсөн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үнэлгээний хөтөлбөрүүдэд оролцож буй Ази, Номхон далайн бүсийн үйлчилгээ үзүүлэгч

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
26

		хөтөлбөрүүд: • IATA IOSA • IATA ISAGO • ACI APEX in Safety • CANSO SoE in SMS 2. Аюулгүй байдлын өгөгдөл хуваалцах хөтөлбөрүүд: • IATA FDX • IATA IDX • FSF ASN	байгууллагуудын тоо; - Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны аюулгүй байдлын өгөгдөл хуваалцах хөтөлбөрүүдэд оролцож буй Ази, Номхон далайн бүсийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын тоо.

ГУРАВ. ИРГЭНИЙ НИСЭХИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮНДЭСНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО

3.1. NASP 2026-2028 нь Монгол Улсын нисэхийн аюулгүй байдлыг сайжруулах зорилготой ерөнхий стратеги төлөвлөгөө мөн.

3.2. Энэхүү төлөвлөгөөг дэлхий болон Ази, Номхон далайн бүс нутгийн түвшинд иргэний нисэхийн аюулгүй байдлын тодорхой эрсдэлүүдийг бууруулах, аюулгүй байдлыг сайжруулах, аюулгүй байдлыг үр дүнтэй хянах чадавхыг сайжруулах зорилгоор “Дэлхийн нисэхийн аюулгүй байдлын төлөвлөгөө”, “Ази, Номхон далайн бүсийн нисэхийн аюулгүй байдлын төлөвлөгөө”-гөөр баталсан аюулгүй байдлыг сайжруулах арга хэмжээнд үндэслэн боловсруулна.

3.3. NASP 2026-2028-д Монгол Улсын иргэний нисэхийн салбарын аюулгүй байдлын асуудлууд, аюулгүй байдлын зорилго, зорилтуудыг тодорхойлж, эдгээр зорилтод хүрэхийн тулд хэрэгжүүлэх шаардлагатай аюулгүй байдлыг сайжруулах арга хэмжээг тусган баталгаажуулна.

ДӨРӨВ. МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АСУУДЛУУД

4.1. Монгол Улсын агаарын тээврийн салбарын онцлог

4.1.1. Иргэний нисэхийн үндсэн хууль, дүрмүүд болон үйл ажиллагааны тусгай журам, зааврууд

4.1.1.1.Иргэний нисэхийн үйл ажиллагаанд мөрдөх хууль, эрх зүйн тогтолцооны бүтцийг энэхүү төлөвлөгөөний Хавсралт 1-т тусгав.

4.1.2. Бодлогын баримт бичиг

4.1.2.1.Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-д *“Зорилт 4.2. Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгоно”* зорилт батлагдсан. Энэхүү зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улс нь агаарын тээврийн либералчлалыг хэрэгжүүлж, нислэгийн чиглэл, тоог нэмэгдүүлэн, агаарын тээвэрлэгчдийн өрсөлдөөнийг дэмжихээр зорьж байна.

4.1.2.2.Мөн зорилт 4.2-ыг хэрэгжүүлэх I үе шат (2021-2030)-д “*10. Иргэний нисэхийн дэд бүтэц, ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлсэн байна.*” гэж тусгагдсан бөгөөд энэ нь ОУИНБ-аас дэвшүүлж буй нислэгийн үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангахад шаардлагатай зохих дэд бүтэц бий болгох зорилгод

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сайд, Төрийн нарийн бичгийн даргын 26 оны А/93 дугаар тушаал

нийцэж байна.

4.1.3. Монгол Улсын агаарын тээврийн салбар

4.1.3.1.Монгол Улсын агаарын тээврийн салбар нь хурдтай хөгжиж байгаа ба 2026 оны 03 дугаар сарын байдлаар жижиг, дунд үйлчилгээ эрхлэгч байгууллагуудтай, 58 агаарын хөлөг бүртгэлтэй байна. Үүнээс 21 нисэх онгоц, 19 нисдэг тэрэг, 16 хэт хөнгөн агаарын хөлөг, 1 туршилтын агаарын хөлөг, 1 агаарын бөмбөлөг, гадаад улсад бүртгэлтэй 6 нисэх онгоцонд ИНЕГ-ын Нислэгт тэнцэх чадварын хэлтэс хяналт тавин ажиллаж байна.

4.1.3.2.ИНЕГ-ын Мэргэжлийн үнэмлэхжүүлэлтийн хэлтэс нь 2026 оны 03 дугаар сарын байдлаар 331 нисгэгч, 269 агаарын хөлгийн инженер, 271 нислэгийн хөдөлгөөний удирдагч, 363 эрүүл мэнд, 368 англи хэлний үнэмлэх гэрчилгээжүүлэлт болон 24 гэрчилгээжсэн нисэхийн сургалтын байгууллагад хяналт зохицуулалт хийж байна.

4.1.3.3.Монгол Улсад 2026 оны 03 дугаар сарын байдлаар 12 агаарын тээвэрлэгчийн гэрчилгээтэй байгууллагууд үйл ажиллагаа явуулж байна.

4.1.3.4.Монгол Улсад агаарын навигацийн үйлчилгээг иргэний нисэхийн дүрмийн хүрээнд гэрчилгээжсэн “ИНҮТ ТӨХХК” дангаар хариуцан эрхэлж байна. Монгол Улсын агаарын зай нь ИНД-71 дүрмийн дагуу A, C, D, G ангилалд хуваагддаг. Монгол Улс нь ОХУ, БНХАУ-тай нийт 16 агаарын хаалгаар холбогддог ба үүнээс ОХУ-тай 10, БНХАУ-тай 6 агаарын хаалгаар холбогдож байна. Мөн Монгол Улсад ИНД-172 дүрмийн дагуу нислэгийн хөдөлгөөний удирдлагын дараах үйлчилгээнүүдийг үзүүлж байна. Үүнд:

- Аэродромын удирдлагын үйлчилгээ (TWR);
- Ойртолтын удирдлагын үйлчилгээ (APP);
- Бүсийн удирдлагын үйлчилгээ (ACC);
- Аэродромын нислэгийн мэдээллийн үйлчилгээ (AFIS);
- Нислэгийн мэдээллийн үйлчилгээ (FIS);
- Аюулын дохио мэдээллийн үйлчилгээ (ALERT).

4.1.3.5.Монгол Улсад нислэгийн хөдөлгөөний бүсийн удирдлагын хариуцлагын бүсийг 6 секторт хуваасан бөгөөд ажиглалтын удирдлагыг 5 секторт, процедур удирдлагыг 1 секторт үзүүлж байна. Монгол Улсын агаарын зайд ИНД-71, ИНД-172 дүрмүүдийн дагуу аюулгүй зайчлалын стандартыг тогтоосон. Ажиглалтын удирдлагад 30 км тууш зайчлал, 10 км-ийн хажуугийн зайчлал, процедур удирдлагад 10 минутын тууш зайчлал, 300м-ийн босоо зайчлалыг тус тус мөрдөж байна.

4.1.3.6.Монгол Улсын агаарын навигацийн үйлчилгээнд 2025 оны байдлаар 600 гаран мэргэшсэн албан хаагчид 7 хоёрдогч радиолокатор (SSR), 14 автомат хамааралтай ажиглалтын систем (ADS-B), AMHS, VPN, VCS, IPRCAG технологиудад суурилсан холбоо, навигаци, ажиглалт, гэрэл суултын 50 гаран байгууламж, 2000 гаруй тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангаж, Ази, Номхон далайн бүсийн (CRV) сүлжээнд холбогдон нислэгийн хөдөлгөөн, нислэгийн урсгал, төлөвлөлт, нисэхийн мэдээлэл солилцон ажиллаж байна.

4.1.3.7.Монгол Улсад 14 аэродромын гэрчилгээ эзэмшигч үүний 2 аэродром нь

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
26

олон улсын, 12 аэродром нь орон нутгийн нисэх буудлын үйлчилгээ үзүүлж байна. Монгол Улсын Засгийн газар болон Япон Улсын Засгийн газрын хооронд байгуулагдсан Концессын гэрээний дагуу "Чингис хаан" ОУНБ-аас орон нутаг, олон улсын бүх төрлийн арилжааны нислэгүүд үйлдэгдэж байна.

4.2. Монгол Улсын иргэний нисэхийн аюулгүй байдлын мэдээллийн санд хийсэн дүн шинжилгээ

4.2.1. Монгол Улсын иргэний нисэхийн үйл ажиллагааны аюулгүй байдлын эрсдэл, ИНЕГ-ын байгууллагын сорилт нь салбарын хэмжээнд аюулгүй байдлын гүйцэтгэлийг зорилтот түвшинд хүргэж, аюулгүй, үр ашигтай, тогтвортой, хүртээмжтэй үйлчилгээг үзүүлэх тогтолцоог бий болгох зорилготой.

4.2.2. Монгол Улсын Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба (цаашид "АХОЗШША" гэх)-ны 2020-2024 оны судалгаагаар ИНД-12 дүрмээр мэдээлэгдсэн агаарын хөлгийн осол, ноцтой зөрчил, зөрчил, дутагдал нийт 178 бүртгэгдсэн байна.

Осол	Ноцтой зөрчил	Зөрчил, дутагдал
2	3	173

4.2.3. АХОЗШША-аас 2020-2024 онд агаарын хөлгийн осол, ноцтой зөрчлийг шинжлэн шалгасан 16 тайлан, 59 аюулгүй байдлйн зөвлөмж гаргасан байна.

4.2.4. 2018-2025 онд ИНЕГ-т дараах аюулгүй байдлын зөрчил, дутагдал бүртгэгдсэн байна:

Д/д	Зөрчил, дутагдлын төрөл								
	Aerodrome incident	Airspace incident	Bird incident	Facility malfunction incident	Defect incident	Other incident	Aircraft incident	Dangerous good incident	Security incident
2018 он	4	10	16	-	6	5	41	1	-
2019 он	4	9	29	-	2	1	26	2	2
2020 он	5	8	13	-	2	2	13	-	-
2021 он	11	8	10	-	2	2	13	-	-
2022 он	4	4	21	-	1	-	13	-	-
2023 он	6	5	12	-	-	3	10	-	-
2024 он	7	5	10	-	1	-	7	-	1
2025 он	6	6	16	52	-	7	47	1	2
Нийт	47	55	127	52	14	20	170	4	5

4.2.5. АХОЗШША болон ИНЕГ-ын аюулгүй байдлын мэдээллийн санд дүн шинжилгээ хийхэд Монгол Улсын иргэний нисэхийн үйл ажиллагаанд дараах төрлийн зөрчил, дутагдал жил бүр давтагдан гарч байгаа нь тогтоогдсон. Үүнд:

- Агаарын зайн зөрчил:
  - Агаарын хөлөг зөвшөөрсөн өндөр хадгалахгүй байх;

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ

- Радио холбоо алдагдах;
- Нисэх баг нислэгийн хөдөлгөөний удирдагчийн захирамж биелүүлэхгүй байх;
- Хилийн бүсэд зөвшөөрөлгүй нислэг үйлдэх;
- Агаарын хөлөг хяналттай агаарын зайд зөвшөөрөлгүй нэвтрэх;
- Дрон, хүнгүй нисэх төхөөрөмж хяналттай агаарын зайд зөвшөөрөлгүй нэвтрэх;
- Нислэгийн хөдөлгөөний удирдагчийн зөвшөөрөлгүй хөөрөлт үйлдэх;
- Зөвшөөрөлгүй шүхэр хаях.

• Аэродромын зөрчил:
- Гадны биет (FOD);
- Хөөрч, буух зурвас мөстөх;
- Агаарын хөлөг хөөрч, буух зурвасаас гарах (Runway excursion);
- Хөөрч, буух зурваст зөвшөөрөлгүй нэвтрэх (Runway incursion).

• Агаарын хөлгийн зөрчил:
- Хүчний төхөөрөмжөөс бусад систем/эд ангийн дутагдал эсхүл эвдрэл;
- Хүчний төхөөрөмжийн систем/эд ангийн дутагдал эсхүл эвдрэл.

• Агаарын хөлгийн бүтцэд орсон эвдрэл, гэмтлээс үүдсэн өөрчлөлт

• Аэродром, нисэх буудал орчмын шувуу, мал, амьтантай холбоотой зөрчил:
- Агаарын хөлөг шувуутай мөргөлдөх;
- Аэродром, нисэх буудлын орчим шувуу бөөгнөрөх;
- Нислэгийн үед агаарын хөлөгт шувуу хэт ойртох;
- Аэродромд мал, амьтан нэвтрэх.

• Аюултай барааны зөрчил

• Байгууламжийн доголдлын зөрчил:
- Ажиглалтын тоног төхөөрөмжийн бэлэн байдал;
- Холбооны тоног төхөөрөмжийн бэлэн байдал;
- Цахилгааны тоног төхөөрөмжийн бэлэн байдал;
- Гэрэлт суулт, навигацийн тоног төхөөрөмжийн бэлэн байдал;
- Цаг уурын тоног төхөөрөмжийн бэлэн байдал.

• Аюулгүйн хамгаалалтын зөрчил

4.3. Монгол Улсын нислэгийн үйл ажиллагааны аюулгүй байдлын эрсдэлүүд:

4.3.1. ИНЕГ нь 2025 онд АХОЗШША, ИНЕГ дээр бүртгэгдсэн 2018-2025 оны аюулгүй байдлын өгөгдөл, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, Монгол Улсын нислэгийн үйл ажиллагааны аюулгүй байдлын эрсдэлүүдийг тодорхойлсон.

4.3.2. Монгол Улс нь NASP 2026-2028-ын дагуу нислэгийн үйл ажиллагааны дараах 10 төрлийн өндөр эрсдэлийн ангилал (National high risk category - N-HRC)-аар агаарын хөлгийн осол, ноцтой зөрчлийг ангилан, дүн шинжилгээ хийнэ. Үүнд:

4.3.2.1.Хяналттай нислэг газрын гадаргууг мөргөх *(Controlled Flight into Terrain – CFIT);*

4.3.2.2.Нислэгийн үеэр удирдлагын жолоо алдагдах *(Loss of Control – In Flight - LOC-I)*;

4.3.2.3.Агаарын хөлгүүд агаарт мөргөлдөх *(Mid-Air Collision – MAC)*;

4.3.2.4.Хөөрч, буух зурвасаас гарах *(Runway Excursion – RE)*;

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сайд Төрийн нарийн бичгийн
дарын 26 А/93 дугаар тушаал

4.3.2.5.Хөөрч, буух зурвас руу зөвшөөрөлгүй нэвтрэх *(Runway Incursion – RI)*;

4.3.2.6.Аэродром дээр болон аэродромын орчинд зэрлэг амьтан, шувуутай мөргөлдөх *(Wildlife Strike – WS)*;

4.3.2.7.Агаарын хөлгийн хөөрч, буух зурвас дахь хэвийн бус буулт - Агаарын хөлөг хатуу буух, агаарын хөлөг сүүл хэсгээрээ газарт хүрэх *(Abnormal Runway Contact - ARC, including Hard Landing and Tail Strike Landing)*;

4.3.2.8.Нислэгийн үед агаарын хөлөг сэгсрэлтэнд орох *(Turbulence encounter – TURB)*;

4.3.2.9.Хүчний төхөөрөмжөөс бусад систем, эд ангийн дутагдал, эсхүл эвдрэл (System/component failure or malfunction *(non-powerplant – SCF-NP)*;

4.3.2.10.Хүчний төхөөрөмжийн систем, эд ангийн дутагдал, эсхүл эвдрэл (System/component failure or malfunction *(powerplant – SCF-PP)*.

4.3.3. Нислэгийн үйл ажиллагааны 10 төрлийн өндөр эрсдэлтэй нөхцөл нь дараах хүчин зүйлээс үүсэх боломжтой ба аюулгүй байдлыг сайжруулах арга хэмжээ нь эдгээр хүчин зүйлийг бууруулахад чиглэгдэнэ:

1) N-HRC 1: Хяналттай нислэг газрын гадаргууг мөргөх *(Controlled Flight into Terrain – CFIT);*
   - Аюултай газрын саад таарах, цаг агаар муу байх;
   - Нисэх баг стандарт үйл ажиллагааны журам (Standard Operating Procedures, цаашид "SOP" гэх)-ыг зөрчих;
   - Нисгэгчийн нөхцөл байдлыг ойлгох чадвар алдагдах;
   - Нисгэгчийн газрын байрлал, газар зүйн онцлогийн талаарх мэдлэг дутмаг байх;
   - Агаарын хөлгийн автомат системд хэт найдах;
   - Байгууллагын зүгээс үйл ажиллагаанд тавих аюулгүй байдал, чанарын хяналт хангалтгүй байх.

2) N-HRC 2: Нислэгийн үеэр удирдлагын жолоо алдагдах (Loss of Control – In Flight - LOC-I):
   - Нисэх баг SOP-ыг зөрчих;
   - Нислэгийн өмнөх төлөвлөлт хангалтгүй байх, хувь хүний ур чадвар, ачааллыг тооцоолоогүй байх;
   - Агаарын хөлгийн хөдөлгүүрт дутагдал гарах, нисгэгчийн онцгой нөхцөлийн үеийн сургалт дадлага хангалтгүй байх;
   - ИНЕГ-ын тогтмол давтамжтай гүйцэтгэх аюулгүй байдлын хяналт шалгалт хангалтгүй байх;
   - Агаарын хөлөг зэрлэг амьтан, шувуутай мөргөлдөх аюулаас сэргийлэх журмын хэрэгжилт хангалтгүй байх.

3) N-HRC 3: Агаарын хөлгүүд агаарт мөргөлдөх (Mid-Air Collision - MAC):
   - Нислэгийн хөдөлгөөний ачаалал нэмэгдэх;
   - Нисгэгч болон нислэгийн хөдөлгөөний удирдагчдын сургалт, дадлага шаардлага хангахгүй байх;
   - Хүчин төгөлдөр гэрээ хэлэлцээр, SOP болон бусад заавар журмыг

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Хаяны 26 А/53

зөрчих.

4) N-HRC 4: Хөөрч, буух зурвасаас гарах (Runway Excursion - RE):
   - Нөхцөл байдлыг ойлгох чадвар алдагдах;
   - Нисэх баг SOP-ыг зөрчих;
   - Сургалт, дадлага хангалтгүй байх /тунадастай хөөрч, буух зурвас дээр буулт үйлдэх, эсхүл crew resource management/;
   - Үйл ажиллагааны зохицуулалт хангалтгүй байх /нисгэгч тунадастай хөөрч, буух зурвас дээр шөнийн нислэг хэрхэн үйлдэх/.

5) N-HRC 5: Хөөрч, буух зурвас руу зөвшөөрөлгүй нэвтрэх (Runway Incursion - RI):
   - Нисгэгчид болон нислэгийн хөдөлгөөний удирдагчдын нөхцөл байдлыг ойлгох чадвар алдагдах;
   - Нисгэгчид болон нислэгийн хөдөлгөөний удирдагчид SOP-ыг зөрчих;
   - Сургалт, дадлага хангалтгүй байх /радио холбоо тогтоох болон CRM/;
   - Агаарын хөлөг шувуу, мал, амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх журмын хэрэгжилт хангалтгүй байх.

6) N-HRC 6: Аэродром дээр болон аэродромын орчинд зэрлэг амьтан, шувуутай мөргөлдөх *(Wildlife Strike – WS)*:
   - Агаарын хөлөг шувуу, мал, амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх журмын хэрэгжилт хангалтгүй байх;
   - Аэродром орчмын зэрлэг амьтан, шувууны амьдрах орчны менежментийн судалгаа хангалтгүй байх.

7) N-HRC 7: Агаарын хөлгийн хөөрч, буух зурвас дахь хэвийн бус буулт - Агаарын хөлөг хатуу буух, агаарын хөлөг сүүл хэсгээрээ газарт хүрэх *(Abnormal Runway Contact - ARC, including Hard Landing and Tail Strike Landing)*:
   - Буултын хурд болон өнцгийг буруу тооцоолох;
   - Тогтворгүй ойртолт хийх;
   - Хүчтэй салхи, огцом салхины өөрчлөлт (wind shear, gust);
   - Сургалт, дадлага хангалтгүй байх;
   - Хөөрч, буух зурвасын нөхцөл байдлыг зохих ёсоор үнэлээгүй.

8) N-HRC 8: Нислэгийн үед агаарын хөлөг сэгсрэлтэнд орох *(Turbulence encounter – TURB)*:
   - Цаг агаарын сүүлийн үеийн мэдээ, сэгсрэлтийн мэдээллийг цаг тухайд нь авахгүй байх;
   - Нислэгийн төлөвлөлтөд сэгсрэлттэй бүсүүдийг зохих ёсоор тусгаагүй байх;
   - Сэгсрэлтийн үед суудлын бүс зүүх дохионы журмыг мөрдөхгүй байх;
   - Сэгсрэлтийн эрсдэлтэй бүсийг мэдсээр байж нислэгийг үргэлжлүүлэх талаарх нисэх багийн шийдвэр.

9) N-HRC 9: Хүчний төхөөрөмжөөс бусад систем/эд ангийн дутагдал эсхүл эвдрэл (System/component failure or malfunction (non-powerplant) - (SCF-NP)):
   - Агаарын хөлгийн системийн дутагдал, далд гэмтэл;
   - Агаарын хөлгийн засвар үйлчилгээ тохиромжгүй байх, үзлэг шалгалт хангалтгүй байх;

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сайд Төрийн нарийн бичгийн
дарга 26 оны 03 сарын 03-ны өдөр

- Агаарын хөлгийн нөөц систем ажиллахгүй байх;
- Нисэх баг SOP-ыг зөрчих.

10) N-HRC 10: Хүчний төхөөрөмжийн систем/эд ангийн дутагдал эсхүл эвдрэл (System/component failure or malfunction (powerplant) - (SCF-PP)):
- Агаарын хөлгийн хөдөлгүүрт гарсан элэгдлээс үүдэлтэй механик эвдрэл;
- Агаарын хөлөг шувуутай мөргөлдөх эсхүл гадны биет сорогдох;
- Агаарын хөлгийн хөдөлгүүрийн засвар, үйлчилгээ хангалтгүй байх;
- Агаарын хөлгийн хөдөлгүүрийн дутагдал гарсан нисэх баг хэрхэн ажиллах тухай сургалт хангалтгүй байх.

4.4. Монгол Улсын иргэний нисэхийн хяналт зохицуулалтын байгууллагын үйл ажиллагаанд тулгарч буй сорилтууд:

4.4.1. Ирээдүйд иргэний нисэхийн аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй улс төр, нийгмийн гадаад, дотоод нөлөөлөл, дэвшилтэт технологийн хөгжил, салбарын үйл ажиллагааны бодлого, үзэл баримтлалын өөрчлөлт, шинэ бизнесс загварууд нь байгууллагын үйл ажиллагаанд сорилтыг бий болгодог. Энэхүү шинэ өөрчлөлт, шилжилтийн үед аюулгүй байдлын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхэд хангалттай өгөгдөл, мэдээлэл дутмаг байдлаас шалтгаалан аюул, эрсдэлийн түвшинг бодитой үнэлэхэд хүндрэл үүсэж болно.

ИНЕГ нь болзошгүй аюулыг урьдчилан илрүүлж, холбогдох мэдээллийг цуглуулан аюулгүй байдлын эрсдэлийг үнэлэх, салбарын аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэхээс сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр зорин ажиллана.

4.4.2. Монгол Улс нь ОУИНБ-ын USOAP-CMA, USAP-CMA аудит болон Үндэсний аудитын газрын аудит, ИНЕГ-ын дотоод хяналт шалгалтуудад зэрэгт үндэслэн ИНЕГ-ийн байгууллагын үйл ажиллагаанд тулгарч буй сорилтуудыг тодорхойлно.

ЗТЯ болон ИНЕГ нь NASP 2026-2028-д олон улсын стандарт шаардлагын дагуу иргэний нисэхийн хяналт, зохицуулалтын байгууллагын сорилтуудыг бууруулж, аюулгүй байдлыг сайжруулах арга хэмжээг тусгаж, иргэний нисэхийн аюулгүй байдлын хяналт зохицуулалтын чадавхыг нэмэгдүүлэхээр төлөвлөсөн.

4.4.3. ОУИНБ нь иргэний нисэхийн аюулгүй байдлын хяналт зохицуулалтыг үнэлэх дараах 8 төрлийн чухал элемент (CE)-ийг тогтоосон ба эдгээр элементийн үр дүнтэй хэрэгжилтийн оноо (EI)-оор ИНЕГ болон АХОЗШША-ны үйл ажиллагааны чадавхыг үнэлнэ. Үүнд:

- CE-1. Иргэний нисэхийн тухай хууль;
- CE-2. Иргэний нисэхийн дүрэм;
- CE-3. Иргэний нисэхийн ерөнхий газрын зохион байгуулалт;
- CE-4. Хяналтын байцаагч нарын мэргэшил, сургалт;
- CE-5. Иргэний нисэхийн хяналтын үйл ажиллагааны журам, заавар, техникийн зааварчилгаа;
- CE-6. Үнэмлэх, зэрэглэл, гэрчилгээ олгох үйл ажиллагаа;
- CE-7. Байнгын хяналт шалгалт;
- CE-8. Аюулгүй байдлын асуудлаар авч буй залруулах арга хэмжээ.

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Хавсралт 26 хуудас А/53 гэсэн тэмдэг

4.4.4. Монгол Улс нь хамгийн сүүлд 2010 онд ОУИНБ-ын USOAP-CMAA бүрэн хэмжээний аудитад хамрагдаж 86.45%, 2017 онд тус аудитаар илэрсэн үл нийцлийг залруулах ICVM шалгалтад хамрагдаж 88.39%-тай үнэлэгдсэн.

ОУИНБ нь 2024 онд USOAP-CMA аудитын хяналтын чиглэл болон протокол шалгах асуултуудыг бүрэн шинэчилж, 9 чиглэлийн 851 асуултаар үнэлэх зохицуулалтыг баталсан. Монгол Улс нь сүүлийн аудитад хамрагдсанаас хойш 10 жилийн дараа шинэ аргачлалаар 2026 оны 04 дүгээр сарын 22-ноос 05 дугаар сарын 05-ны хооронд аудитад хамрагдахаар төлөвлөж байна. Дээрх хугацаанд салбарын үйл ажиллагааны өсөлт болон ИНЕГ-ын зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагаанд их хэмжээний өөрчлөлт гарсан.

4.4.5. ИНЕГ нь 2026 оны USOAP-CMA аудитад бэлтгэх зорилгоор ОУИНБ-ын Ази, Номхон далайн бүсийн төвөөс CAT mission багийн зөвлөх үйлчилгээг авч, 2025 оны 03 болон 09 дүгээр сард аудитын протокол шалгах асуултаар урьдчилсан шалгалтад хамрагдаад байна. Тус шалгалтаар илэрсэн үл нийцэл болон аудитын бэлтгэлд хийсэн ажлын хэсгийн үнэлгээгээр ИНЕГ болон АХОЗШША-нд CE-1 - CE-8 түвшний олон төрлийн нийтлэг асуудлууд илэрсэн. Иймд иргэний нисэхийн хяналт зохицуулалтын байгууллагын сорилтыг дараах 9 чиглэлийн CE-1 - CE-8 түвшний асуудлуудаар тодорхойлж, залруулахаар төлөвлөсөн. Үүнд:

- LEG - Иргэний нисэхийн тухай хууль тогтоомж, иргэний нисэхийн дүрэм, журам;
- ORG - Иргэний нисэхийн хяналт зохицуулалтын байгууллага;
- PEL - Мэргэжлийн үнэмлэхжүүлэлт;
- OPS - Нислэгийн үйл ажиллагаа;
- AIR - Агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадвар;
- AIG - Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах;
- ANS - Агаарын навигацийн үйлчилгээ;
- AGA - Аэродром, газрын туслах хэрэгсэл;
- SSP - Иргэний нисэхийн аюулгүй байдлын хөтөлбөр (SSP).

4.5. Цаашид судлах, анхаарах шаардлагатай асуудлууд

4.5.1. NASP 2026-2028-д иргэний нисэхийн аюулгүй байдалд нөлөөлөхүйц шинээр гарч ирж буй асуудлуудыг хөндсөн. Хангалттай аюулгүй байдлын өгөгдөл байхгүйн улмаас эдгээр асуудлууд нь үйл ажиллагааны эрсдэлд шууд тооцогдох боломжгүй тул цаашид үүсэх боломжтой аюулыг илрүүлэх, зохих эрсдэлийн хамгаалалтыг бий болгох, холбогдох өгөгдлийг цуглуулах, эрсдэлийг бууруулах арга хэмжээг авах зэргээр үйл ажиллагааг тогтмол хянах шаардлагатай.

4.5.2. Монгол Улсад ирэх жилүүдэд үүсэх боломжтой, аюулгүй байдлын өгөгдлийг цуглуулж, дүн шинжилгээ хийх шаардлагатай дараах асуудлуудыг тодорхойлж байна. Үүнд:

1) Монгол Улс руу ирж, очих арилжааны нислэгийн урсгалын мэдэгдэхүйц өсөлт;
2) Монгол Улсын агаарын зай болон аэродромын орчин дахь хүнгүй нисэх төхөөрөмж (Unmanned aerial vehicles - UAV)-ийн үйл ажиллагаа;
3) Дэвшилтэт нисэх төхөөрөмжүүдэд зориулан хүнгүй агаарын хөлгийн систем (Unmanned aircraft system - UAS)-ийн нислэгийн хөдөлгөөний удирдлагыг бий болгох зорилгоор агаарын навигацийн үйлчилгээний

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ

системийг өөрчлөн, сайжруулах;

4) Ерөнхий зориулалтын нислэгийн үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангуулах зорилгоор салбарын оролцогч талуудын эрх зүйн зохицуулалтыг сайжруулах хэрэгцээ;
5) Агаарын навигацийн системийн дэд бүтцийг шинэчилж, сайжруулах;
6) Орон нутгийн нисэх буудлуудын дэд бүтцийг эдийн засгийн судалгаа, салбарын стратеги төлөвлөлтөд уялдуулан хөгжүүлэх;
7) Иргэний нисэхийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй системүүдийн мэдээллийн аюулгүй байдал;
8) Салбарын мэргэжлийн хүний нөөцийн дутагдал, шинээр хүний нөөцийг шат дараалалтай бэлтгэх бодлогыг гаргах, хяналт шалгалт, бодлогын түвшинд ажиллах мэргэшсэн ажилтнуудыг цалин хөлсний бодлогоор тогтвортой ажиллуулах нөхцөлийг бий болгож, иргэний нисэхийн хяналт зохицуулалтын тогтолцоог бэхжүүлэх;
9) Иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангуулахтай холбогдуулан аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог иргэний нисэхийн дүрмээр гэрчилгээжсэн байгууллагуудад бүрэн хэрэгжүүлэх;
10) Аюулгүй байдлын мэдээлэл солилцох явцыг дэмжих зорилгоор аюулгүй байдлын мэдээллийг цуглуулж, боловсруулах тогтолцоо (SDCPS)-г бий болгох.

ТАВ. МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ НИСЭХИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН УДИРДЛАГЫН СТРАТЕГИ ЧИГЛЭЛ

5.1 Монгол Улсын нисэхийн аюулгүй байдлыг сайжруулах зорилго, зорилт:

5.1.1. Монгол Улсын хэмжээнд SSP-ээр тогтоосон аюулгүй байдлын бодлого, зорилтыг хэрэгжүүлэх, иргэний нисэхийн аюулгүй байдлыг сайжруулахын тулд ЗТЯ болон ИНЕГ нь 2026-2028 он хүртэл дараах зорилго, зорилтуудыг хэрэгжүүлнэ:

Зорилго	Зорилт		Хэмжих үзүүлэлт
1. Улсын хэмжээнд нислэгийн үйл ажиллагааны аюулгүй байдлын өндөр эрсдэлийг тогтвортойгоор бууруулах.	1.1.	2026-2028 онд хүний амь нас эрсдэсэн агаарын хөлгийн осол гаргахгүй байх.	- Ослын түвшин (10,000 хөөрөлт, буултын нислэг тутамд ногдох ослын тоо); - Хүний амь нас эрсдэсэн ослын түвшин (10,000 хөөрөлт, буултын нислэг тутамд ногдох хүний амь нас эрсдэсэн ослын тоо); - Хүний амь нас эрсдэсэн түвшин (1 сая тээвэрлэсэн зорчигч тутамд ногдох хүний амь нас эрсдэсэн тоо).
	1.2.	2026-2028 онд агаарын хөлгийн ослоос шалтгаалан агаарын хөлгийн бүтцэд гэмтэл учруулах тохиолдол гаргахгүй байх.	- N-HCR-ээр ангилсан ослын түвшин; - N-HCR-ээр ангилсан ноцтой зөрчлийн түвшин; - Нийт агаарын хөлгийн осолтой харьцуулахад

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сайд Төрийн нарийн бичгийн
даргын 26 А/53 тушаал

			N-HCR-т хамаарах ослын хувь.
	1.3.	2028 он гэхэд ноцтой зөрчлийн тоог 50%-иар бууруулах.	- Аюулгүй байдлын эрсдэлийн ангиллаар тооцсон ноцтой зөрчлийн тоо.
2. Иргэний нисэхийн хяналт, зохицуулалтын болон агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны чадамжийг бэхжүүлэх.	2.1.	2028 он гэхэд Монгол Улсын иргэний нисэхийн аюулгүй байдлын хяналт зохицуулалтын байгууллага (ИНЕГ) болон Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах байгууллага (АХОЗШША)-ыг үндэсний болон олон улсын үүргээ биелүүлэхэд шаардлагатай хангалттай хэмжээний санхүүгийн нөөцөөр хангасан байх.	ОУИНБ-ын USOAP-CMA-ын протокол асуулт (PQ) 2.0512-оор “хангалттай” үнэлгээ авсан байх.
	2.2.	Иргэний нисэхийн аюулгүй байдлын хяналт зохицуулалт, агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах байгууллагын чадавхыг бэхжүүлэх: 1) 2026 онд - бүх чиглэлээр CE-ийн EI-г 75%-д хүрэх; 2) 2027 онд - бүх чиглэлээр CE-ийн EI-г 85%-д хүрэх; 3) 2028 онд - бүх чиглэлээр CE-ийн EI-г 95%-д хүрэх.	ОУИНБ-ын USOAP-CMA-ын протокол асуулт (PQ)-аар “хангалттай” үнэлгээ авсан байх.
	2.3.	ИНЕГ нь ОУИНБ-ын USOAP-CMA-ын протокол асуулт (PQ)-ын дагуу бие даасан үнэлгээ (self-assessment) хийж, OLF системийг тогтмол шинэчлэх.	- ОУИНБ-ын USOAP-CMA-ын протокол асуулт (PQ)-аар “хангалттай” үнэлгээ авсан байх. - OLF системд self-assessment, CAP, CC/EFOD, SAAQ-г тогтмол шинэчилсэн байх.
	2.4.	2026-2028 онд жил бүр ИНЕГ-ын иргэний нисэхийн хяналт шалгалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг 100% хангасан байх.	Хяналт шалгалтын төлөвлөгөөний гүйцэтгэлийн хувь
	2.5.	2026-2028 онд агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах шинжээч болон иргэний нисэхийн хяналтын байцаагчийн сургалт, дадлага (CE-4)-ын үр дүнтэй хэрэгжилтийн оноо (EI)-г тасралтгүй сайжруулах. USOAP-CMA аудитаар дэлхийн суурь дундаж 65% онооноос доогуур оноотой үнэлэгдэхгүй байх.	- CE-4/AIG-ийн хувь; - CE-4/ИНЕГ-ийн хувь. - Жил бүрийн сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь.
	2.6.	2028 он гэхэд аюулгүй байдлын	CE-8-ийн хувь.

МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сайд Төрийн нарийн бичгийн дарга 26 сар 493 дугаар тушаал

		асуудлыг шийдвэрлэх (CE-8) түвшний үр дүнтэй хэрэгжилтийн оноо (EI)-г сайжруулж, дэлхийн суурь дундаж 70-75% онооноос доогуур оноогоор үнэлэгдэхгүй байх.	
3. SSP болон SMS-г үр дүнтэй хэрэгжүүлж, хэрэгжилтэд байнгын хяналт тавих.	3.1.	2026-2028 онд SSP-NASP-ын хэрэгжилтийг дараах байдлаар хангуулна: 1) 2026 онд – 30%; 2) 2028 онд – 100%.	- NASP-аар төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг хувь; - Жил бүрийн SSP хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь.
4. Иргэний нисэхийн аюулгүй байдлыг дээшлүүлэхийн тулд дэлхийн болон бүс нутгийн хэмжээнд хамтын ажиллагааг өргөжүүлж, бэхжүүлэх.	4.1.	2026 онд Монгол Улс иргэний нисэхийн аюулгүй байдлын хяналт зохицуулалтын чадавхаа нэмэгдүүлэх, эсхүл SSP-тэй холбоотой PQ-ийн хэрэгжилтийг хангах чиглэлээр ОУИНБ болон бусад олон улсын байгууллагуудаас мэргэжлийн туслалцаа, дэмжлэг авах.	Мэргэжлийн туслалцаа, дэмжлэг авсан хамтын ажиллагааны тоо.
	4.2.	2026-2028 онд Монгол Улс жил бүрийн Ази, Номхон далайн бүсийн аюулгүй байдлын бүлгийн уулзалтад оролцож, үйл ажиллагаанд учрах эрсдэл, үүссэн асуудлынхаа талаар мэдээлэл солилцсон байх.	AP-RASG уулзалтад оролцсон тоо.
	4.3.	2026 онд Ази, Номхон далайн бүсийн аюулгүй байдлын үнэлгээний техникийн багт иргэний нисэхийн хяналтын байцаагчийг гишүүнээр томилж, жил бүрийн уулзалт, семинарт хамруулах.	AP-RASG-ийн техникийн багийн уулзалт, семинарт оролцсон тоо.
	4.4.	2027 он гэхэд Ази, Номхон далайн бүсийн төвийн иргэний нисэхийн аюулгүй байдлын төлөвлөлтийн зорилгоор үйл ажиллагааны аюулгүй байдлын эрсдэл болон шинээр гарч буй асуудлуудын талаарх мэдээллийг ашиглах механизмд нэгдэх.	- Монгол Улс ОУИНБ-ын “Operational Safety Risks & Emerging Issues” аюулгүй порталд бүртгэгдсэн эсэх; - Үйл ажиллагааны аюулгүй байдлын эрсдэл ба шинээр гарч буй асуудлуудын талаар тус порталаар дамжуулан хүргүүлсэн тайлангийн тоо.
	4.5.	2026-2028 онд ОУИНБ болон салбарын бусад олон улсын нисэхийн салбарын хурал, уулзалт, семинар, сургалтад	- Гадаад арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт.

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сайд Төрийн нарийн бичгийн
дарга 26 он 193 дугаар тушаал

		гадаад арга хэмжээний төлөвлөгөөний дагуу идэвхтэй хамрагдах.	
5. Иргэний нисэхийн оролцогч талуудыг хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдэд татан оролцуулж, хамтын ажиллагааг дэмжих, аюулгүй байдлын мэдээлэл дамжуулах тогтолцоог бий болгох.	5.1.	Салбарын нийт оролцогчдыг хамруулсан аюулгүй байдлын өгөгдөл дамжуулах, цуглуулах, дүн шинжилгээ хийх тогтолцоог бий болгож, тогтвортой ажиллуулах.	- MOR тоо; - VOR тоо; - Аюулгүй байдлын өгөгдөлд дүн шинжилгээ хийж, иргэний нисэхийн аюулгүй байдлын журмыг хэрэгжүүлэх техникийн багаар эрсдэлийн үнэлгээ хийсэн тоо.
	5.2.	Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөлийн хуралдааныг SSP-ийн дагуу зохион байгуулах. Салбарын хэмжээнд хурал, зөвлөгөөн, сургалтыг зохион байгуулж, идэвхтэй хамтын ажиллагааг дэмжих.	- Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөлийн хуралдааны тоо, хурлын шийдвэрийн хэрэгжилтийн хувь. - Салбарын хэмжээнд зохион байгуулагдсан хурал, зөвлөгөөн, сургалтын тоо.
6. Нислэгийн аюулгүй байдлыг хангахад шаардлагатай зохих дэд бүтэц бий болсон эсэхийг бататгаж, салбарын хэмжээнд хэрэгжих төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах.	6.1.	2028 он гэхэд үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд дараах хөтөлбөрүүдийг ашиглах хэмжээг нэмэгдүүлэх. 1. Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үнэлгээний хөтөлбөрүүд: • IATA IOSA • IATA ISAGO • ACI APEX in Safety • CANSO SoE in SMS 2. Аюулгүй байдлын өгөгдөл хуваалцах хөтөлбөрүүд: • IATA FDX • IATA IDX • FSF ASN	- ОУИНБ-аас хүлээн зөвшөөрсөн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үнэлгээний хөтөлбөрүүдэд оролцож буй үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын тоо; - Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны аюулгүй байдлын өгөгдөл хуваалцах хөтөлбөрүүдэд оролцож буй үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын тоо.
	6.2.	1. 2027 онд Монгол Улсын агаарын навигацийн үндэсний төлөвлөгөөг батлуулах. 2. 2028 онд Монгол Улсын агаарын навигаци, аэродром, нисэх буудлын дэд бүтцийг ОУИНБ-ын стандартад нийцүүлэх.	- Монгол Улсын агаарын навигацийн үндэсний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь.

5.1.2. Монгол Улсын иргэний нисэхийн аюулгүй байдлын зорилго, зорилт, хэрэгжилтийг хянах үзүүлэлтүүд нь ОУИНБ-ын зорилго, зорилт, үзүүлэлтүүдэд бүрэн нийцсэн болно.

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ

5.2. Иргэний нисэхийн аюулгүй байдлын гүйцэтгэлийн үзүүлэлт, зорилтот түвшинг тогтоох

5.2.1. Улсын хэмжээнд хянах иргэний нисэхийн аюулгүй байдлын гүйцэтгэлийн үзүүлэлтийг ОУИНБ-аас гаргасан нислэгийн үйл ажиллагааны аюулгүй байдлын өндөр эрсдэлийн ангиллаар тогтооно.

5.2.2. Монгол Улс нь иргэний нисэхийн аюулгүй байдлын зорилго, зорилтод уялдуулан, аюулгүй байдлын гүйцэтгэлийн үзүүлэлтээс шалтгаалсан агаарын хөлгийн ослын тохиолдол 2026-2027 онд гаргахгүй байх буюу “0” утга байхаар зорилтот түвшинг тогтоов. Үүнд:

Д/д	Аюулгүй байдлын гүйцэтгэлийн үзүүлэлт (SPI)	Аюулгүй байдлын гүйцэтгэлийн зорилтот түвшин (SPT) 2026-2027 онд
SPI 1	Хяналттай нислэг газрын гадаргууг мөргөх *(Controlled Flight into Terrain – CFIT);*	Агаарын хөлгийн осол - 0
SPI 2	Нислэгийн үеэр удирдлагын жолоо алдагдах *(Loss of Control – In Flight - LOC-I)*	
SPI 3	Агаарын хөлгүүд агаарт мөргөлдөх *(Mid-Air Collision – MAC)*	
SPI 4	Хөөрч, буух зурвасаас гарах *(Runway Excursion – RE)*	
SPI 5	Хөөрч, буух зурвас руу зөвшөөрөлгүй нэвтрэх *(Runway Incursion – RI)*	
SPI 6	Аэродром дээр болон аэродромын орчинд зэрлэг амьтан, шувуутай мөргөлдөх *(Wildlife Strike – WS)*	
SPI 7	Агаарын хөлгийн хөөрч, буух зурвас дахь хэвийн бус буулт - Агаарын хөлөг хатуу буух, агаарын хөлөг сүүл хэсгээрээ газарт хүрэх *(Abnormal Runway Contact - ARC, including Hard Landing and Tail Strike Landing)*	
SPI 8	Нислэгийн үед агаарын хөлөг сэгсрэлтэнд орох *(Turbulence encounter – TURB);*	
SPI 9	Хүчний төхөөрөмжөөс бусад систем, эд ангийн дутагдал, эсхүл эвдрэл (System/component failure or malfunction *(non-powerplant – SCF-NP);*	
SPI 10	Хүчний төхөөрөмжийн систем, эд ангийн дутагдал, эсхүл эвдрэл (System/component failure or malfunction *(powerplant – SCF-PP).*	

5.2.3. Монгол Улс нь цаашид аюулгүй байдлын гүйцэтгэлийн үзүүлэлтийн зорилтот болон хүлээн зөвшөөрөгдөх түвшинг богино, дунд хугацаагаар төлөвлөн, NASP-д тусган баталгаажуулна. Аюулгүй байдлын гүйцэтгэлийг тоон утгаар хэмжих бөгөөд статистик аргачлалаар дүн шинжилгээ хийнэ.

5.2.4. ИНЕГ-ын иргэний нисэхийн аюулгүй байдлын журмыг хэрэгжүүлэх техникийн баг нь аюулгүй байдлын өгөгдөлд хийсэн дүн шинжилгээнд үндэслэн аюулгүй байдлын гүйцэтгэлийн үзүүлэлтийг шинэчлэх, нарийвчлан сайжруулах, зорилтот түвшинг судалгаанд үндэслэн тогтоох үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ

5.3. Иргэний нисэхийн аюулгүй байдлын эрсдэлийн хамгаалалтад хяналт тавих

5.3.1. ИНЕГ нь иргэний нисэхийн аюулгүй байдлын эрсдэлийн хамгаалалтыг бий болгох зорилгоор 2026-2028 онд дараах үйл ажиллагаанд анхаарч, холбогдох судалгааг гүйцэтгэн, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

- Иргэний нисэхийн хяналт зохицуулалтын үйл ажиллагааны чадавхыг бэхжүүлэх;
- Иргэний нисэхийн дүрмээр гэрчилгээжсэн байгууллагуудын SMS-ийн хэрэгжилтийг хангуулах;
- АХОЗШША-аас гаргасан аюулгүй байдлын зөвлөмжийг хэрэгжүүлэх;
- Аюулгүй байдлын мэдээлэл солилцох явцыг дэмжих зорилгоор аюулгүй байдлын мэдээллийг цуглуулж, боловсруулах тогтолцоо (SDCPS)-г бий болгох;
- Аюулгүй байдлын эрэг соёлыг салбарын хэмжээнд үе шаттайгаар нэвтрүүлэх;
- Агаарын навигацийн системийн дэд бүтцийг шинэчилж, сайжруулах;
- Ерөнхий зориулалтын нислэгийн үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангуулах зорилгоор салбарын оролцогч талуудын эрх зүйн зохицуулалтыг сайжруулах;
- Агаарын навигацийн системийн дэд бүтцийг шинэчилж, сайжруулах;
- Иргэний нисэхийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй системүүдийн мэдээллийн аюулгүй байдлыг сайжруулах;
- Салбарын мэргэжлийн хүний нөөцийн дутагдал, шинээр хүний нөөцийг шат дараалалтай бэлтгэх бодлогыг гаргах, хяналт шалгалт, бодлогын түвшинд ажиллах мэргэшсэн ажилтнуудыг цалин хөлсний бодлогоор тогтвортой ажиллуулах нөхцөлийг бий болгож, иргэний нисэхийн хяналт зохицуулалтын тогтолцоог бэхжүүлэх;
- Хүнгүй нисэх төхөөрөмжийн үйл ажиллагааны аюулгүй байдлын хангуулах;
- Иргэний нисэхийн салбарын онцгой нөхцөл, онцгой байдлын үеийн төлөвлөлтийг бэхжүүлэх.

5.4. Монгол Улсын нисэхийн аюулгүй байдлын удирдлагын стратеги чиглэл

5.4.1. ИНЕГ нь SSP-ээр тогтоосон иргэний нисэхийн аюулгүй байдлын бодлого болон энэхүү төлөвлөгөөний 6.1.1-т тусгасан аюулгүй байдлын зорилго, зорилтыг хэрэгжүүлэх, аюулгүй байдлыг сайжруулах арга хэмжээг ОУИНБ-ын “DOC 10161. Дэлхийн нисэхийн аюулгүй байдлын замын зураглал”-д нийцүүлэн боловсруулж, энэхүү төлөвлөгөөний Хавсралт 2-т тусгав.

5.4.2. Дээрх арга хэмжээг иргэний нисэхийн хяналт зохицуулалт, агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаа болон иргэний нисэхийн дүрмээр гэрчилгээжсэн үйлчилгээ эрхлэгч байгууллагуудын SMS-т тулгуурлан хэрэгжүүлнэ.

ЗУРГАА. ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ

6.1. ИНЕГ-ын аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо хариуцсан нэгж нь энэхүү төлөвлөгөөний Хавсралт 2, Хавсралт 3, Хавсралт 4-т тусгагдсан

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ

аргачлалаар NASP-аар тогтоосон зорилго, зорилт болон аюулгүй байдлыг сайжруулах арга хэмжээний хэрэгжилтэд хагас жил тутам хяналт тавина.

6.2. ИНЕГ нь 3 жил тутам, эсхүл шаардлагатай тохиолдолд NASP-д дүн шинжилгээ хийж, нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулна.

6.3. ИНЕГ нь жил бүр төлөвлөгөөний хэрэгжилтэд үндэслэн аюулгүй байдлын гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж, Монгол Улсын иргэний нисэхийн аюулгүй байдлын гүйцэтгэлийн зорилтот түвшинг боловсруулан, Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөлөөр батлуулна.

6.4. ИНЕГ нь Монгол Улсад иргэний нисэхийн аюулгүй байдлыг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор ОУИНБ болон салбарын бусад оролцогч талуудаас дэмжлэг, туслалцаа авна.

6.5. ИНЕГ нь аюулгүй байдлыг сайжруулах арга хэмжээний хэрэгжилт, аюулгүй байдлын гүйцэтгэлийн зорилтот түвшин хангагдаж байгаа эсэхийг баталгаажуулж, салбарын нийт оролцогч талуудад жил бүр танилцуулна.

6.6. ИНЕГ нь тухайн жилийн аюулгүй байдлын зорилтот түвшин хангагдаагүй тохиолдолд суурь шалтгааныг тодорхойлсон байна. Хэрэв ИНЕГ-аас нислэгийн үйл ажиллагаа дахь ноцтой эрсдэлийг илрүүлсэн бол эрсдэлийг бууруулах арга хэмжээг шуурхай авч, NASP-д яаралтай нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулна.

6.7. ИНЕГ нь ОУИНБ-ын Ази, Номхон далайн бүс нутгийн төвд тайлан, мэдээлэл дамжуулах журмыг тогтоосон байна. Энэ нь бүс нутгийн хэмжээнд иргэний нисэхийн аюулгүй байдлыг хариуцсан байгууллагууд шаардлагатай мэдээллийг авч, нэгдсэн аргачлалаар эрсдэлийг үнэлэх боломжийг бий болгоно.

---oOo---

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВЭРЧИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ

ХАВСРАЛТ 1

МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ



/График 1. Монгол Улсын Иргэний нисэхийн эрх зүйн зохицуулалт/

МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сайд, Төрийн нарийн бичгийн дарын 26 он К/93 тушаар үүсгэв

ИРГЭНИЙ НИСЭХИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

I. УЛСЫН ХЭМЖЭЭНД НИСЛЭГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ӨНДӨР ЭРСДЭЛИЙГ ТОГТВОРТОЙГООР БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР */OPERATIONAL SAFETY RISKS (OPS) ROADMAP/:*

NASP | Зорилго 1	**Монгол Улсын хэмжээнд нислэгийн үйл ажиллагааны аюулгүй байдлын өндөр эрсдэлийг тогтвортойгоор бууруулах.**
NASP | Зорилт 1.1	2026-2028 онд хүний амь нас эрсэдсэн агаарын хөлгийн осол гаргахгүй байх.
NASP | Зорилт 1.2	2026-2028 онд агаарын хөлгийн ослоос шалтгаалан агаарын хөлгийн бүтцэд гэмтэл учруулах тохиолдол гаргахгүй байх.
NASP | Зорилт 1.3	2028 он гэхэд ноцтой зөрчлийн тоог 50%-иар бууруулах.
Нислэгийн үйл ажиллагааны эрсдэлүүд */Operational safety risks/*: 1. N-HRC 1: Хяналттай нислэг газрын гадаргууг мөргөх *(Controlled Flight into Terrain – CFIT);* 2. N-HRC 2: Нислэгийн үеэр удирдлагын жолоо алдагдах *(Loss of Control – In Flight - LOC-I)*; 3. N-HRC 3: Агаарын хөлгүүд агаарт мөргөлдөх *(Mid-Air Collision – MAC)*; 4. N-HRC 4: Хөөрч, буух зурвасаас гарах *(Runway Excursion – RE)*; 5. N-HRC 5: Хөөрч, буух зурвас руу зөвшөөрөлгүй нэвтрэх *(Runway Incursion – RI)*; 6. N-HRC 6: Аэродром дээр болон аэродромын орчинд зэрлэг амьтан, шувуутай мөргөлдөх *(Wildlife Strike – WS)*; 7. N-HRC 7: Агаарын хөлгийн хөөрч, буух зурвас дахь хэвийн бус буулт - Агаарын хөлөг хатуу буух, агаарын хөлөг сүүл хэсгээрээ газарт хүрэх *(Abnormal Runway Contact - ARC, including Hard Landing and Tail Strike Landing)*; 8. N-HRC 8: Нислэгийн үед агаарын хөлөг сэгсрэлтэнд орох *(Turbulence encounter – TURB)*; 9. N-HRC 9: Хүчний төхөөрөмжөөс бусад систем, эд ангийн дутагдал, эсхүл эвдрэл (System/component failure or malfunction *(non-powerplant – SCF-NP)*; 10. N-HRC 10: Хүчний төхөөрөмжийн систем, эд ангийн дутагдал, эсхүл эвдрэл (System/component failure or malfunction *(powerplant – SCF-PP)*.	
Зорилго 1 | Зорилт 1.1-1.3-ыг хэрэгжүүлэх зорилгоор дараах аюулгүй байдлыг сайжруулах арга хэмжээ (SEIs)-г авч хэрэгжүүлнэ.	
OPS.1 - SEI 1. CFIT эрсдэлд хүргэх хүчин зүйлийг багасгах.	
OPS.2 - SEI 2. LOC-I эрсдэлд хүргэх хүчин зүйлийг багасгах.	
OPS.3 - SEI 3. MAC эрсдэлд хүргэх хүчин зүйлийг багасгах.	
OPS.4 - SEI 4. RE эрсдэлд хүргэх хүчин зүйлийг багасгах.	
OPS.5 - SEI 5. RI эрсдэлд хүргэх хүчин зүйлийг багасгах.	
OPS.6 - SEI 6. WS эрсдэлд хүргэх хүчин зүйлийг багасгах.	
OPS.7 - SEI 7. ARC эрсдэлд хүргэх хүчин зүйлийг багасгах.	

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
26 11/93

OPS.8 - SEI 8. TURB эрсдэлд хүргэх хүчин зүйлийг багасгах.
OPS.9 - SEI 9. SCF-NP эрсдэлд хүргэх хүчин зүйлийг багасгах.
OPS.10 - SEI 10. SCF-PP эрсдэлд хүргэх хүчин зүйлийг багасгах.

II. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТУЛГАРЧ БУЙ СОРИЛТУУД */ORGANISATIONAL SAFETY RISKS (ORG) ROADMAP:*

NASP | Зорилго 2: Иргэний нисэхийн хяналт, зохицуулалтын болон агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны чадамжийг бэхжүүлэх.
NASP | Зорилт 2.1: Монгол Улсын нисэхийн аюулгүй байдлын хяналтын чадамжийг сайжруулах зорилгоор хангалттай хэмжээний санхүүгийн нөөцийг бий болгох. NASP | Зорилт 2.2: Иргэний нисэхийн аюулгүй байдлын хяналт зохицуулалт, агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах байгууллагын чадавхыг бэхжүүлэх: • 2026 онд - бүх чиглэлээр CE-ийн EI-г 75%-д хүрэх; • 2027 онд - бүх чиглэлээр CE-ийн EI-г 85%-д хүрэх; • 2028 онд - бүх чиглэлээр CE-ийн EI-г 95%-д хүрэх. NASP | Зорилт 2.3: ИНЕГ нь ОУИНБ-ын USOAP-CMA-ын протокол асуулт (PQ)-ын дагуу бие даасан үнэлгээ (self-assessment) хийж, OLF системийг тогтмол шинэчлэх. NASP | Зорилт 2.4: 2026-2028 онд жил бүр ИНЕГ-ын иргэний нисэхийн хяналт шалгалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг 100% хангасан байх. NASP | Зорилт 2.5: 2026-2028 онд агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах шинжээч болон иргэний нисэхийн хяналтын байцаагчийн сургалт, дадлага (CE-4)-ын үр дүнтэй хэрэгжилтийн оноо (EI)-г тасралтгүй сайжруулах. USOAP-CMA аудитаар дэлхийн суурь дундаж 65% онооноос доогуур оноотой үнэлэгдэхгүй байх. NASP | Зорилт 2.6: 2028 он гэхэд аюулгүй байдлын асуудлыг шийдвэрлэх (CE-8) түвшний үр дүнтэй хэрэгжилтийн оноо (EI)-г сайжруулж, дэлхийн суурь дундаж 70-75% онооноос доогуур оноогоор үнэлэгдэхгүй байх.
Зорилго 2 | Зорилт 2.1-2.6-г хэрэгжүүлэх зорилгоор дараах аюулгүй байдлыг сайжруулах арга хэмжээ (SEIs)-г авч хэрэгжүүлнэ.
ORG.1 – SEI 11. ОУИНБ-ын стандарт, зөвлөмжийг тууштай хэрэгжүүлэх. ORG.2 – SEI 12. Иргэний нисэхийн хяналт зохицуулалтын тогтолцоог бүрдүүлэх. ORG.3 – SEI.13 Олон Улсын иргэний нисэхийн Чикагогийн конвенцын Хавсралт 13. Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах стандартын дагуу хараат бус Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах тогтолцоог бүрдүүлэх. ORG.4 – SEI 14. Иргэний нисэхийн хяналт зохицуулалтын тогтолцооны үр дүнтэй байдлыг хангах зорилгоор нөөцийг бодлогоор хуваарилах.

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
26 А/93

ORG.5 – SEI 15. Үр дүнтэй иргэний нисэхийн хяналт зохицуулалтыг хэрэгжүүлэх мэргэшсэн хүний нөөцийг бүрдүүлэх. ORG.6 – SEI 16. Аюулгүй байдлыг зохион байгуулалттайгаар сайжруулахын тулд гол салбарын оролцогч талуудтай стратегийн хамтын ажиллагаа байгуулах. ORG.7 – SEI 17. ОУИНБ-ын аюулгүй байдлын анхан шатны мэдээллийн эх сурвалж болж, холбогдох бүх баримт бичиг, бүртгэлийг бүрдүүлж, хүргүүлэх. ORG.8 – SEI 18. ОУИНБ-ын стандарт, зөвлөмжийг үндэсний түвшинд тогтвортой хэрэгжүүлэх. ORG.9 – SEI 19. ОУИНБ-ын стандарт, зөвлөмжийг үндэсний түвшинд тогтвортой хэрэгжүүлэх. ORG.10 – SEI 20. Аюулгүй байдлын үр дүнтэй хяналт зохицуулалтыг бий болгох үүднээс стратегийн түвшинд нөөцийг оновчтой хуваарилах. ORG.11 – SEI 21. Салбарын оролцогч гол талуудтай стратегийн хамтын ажиллагаа явуулж, аюулгүй байдлын зохицуулалтыг сайжруулах.

NASP | Зорилго 5: Иргэний нисэхийн оролцогч талуудыг хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдэд татан оролцуулж, хамтын ажиллагааг дэмжих, аюулгүй байдлын мэдээлэл дамжуулах тогтолцоог бий болгох.
NASP | Зорилт 5.1: Салбарын нийт оролцогчдыг хамруулсан аюулгүй байдлын өгөгдөл дамжуулах, цуглуулах, дүн шинжилгээ хийх тогтолцоог бий болгож, тогтвортой ажиллуулах. NASP | Зорилт 5.2: Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөлийн хуралдааныг SSP-ийн дагуу зохион байгуулах. Салбарын хэмжээнд хурал, зөвлөгөөн, сургалтыг зохион байгуулж, идэвхтэй хамтын ажиллагааг дэмжих.
Зорилго 5 | Зорилт 5.1-5.2-г хэрэгжүүлэх зорилгоор аюулгүй байдлыг сайжруулах дараах арга хэмжээ (SEIs)-г авч хэрэгжүүлнэ.
ORG.16 – SEI.26 | Улсын хэмжээнд иргэний нисэхийн аюулгүй байдлын удирдлагын үйл ажиллагааг дэмжих аюулгүй байдлын өгөгдөл, мэдээллийн хүртээмж (1-р алхам) ORG.17 – SEI.27 | Улсын хэмжээнд иргэний нисэхийн аюулгүй байдлын удирдлагын үйл ажиллагааг дэмжих аюулгүй байдлын өгөгдөл, мэдээллийн хүртээмж (2-р алхам) ORG.18 – SEI.28 | Гол агаарын тээврийн оролцогч талуудтай стратегийн хамтын ажиллагааг хөгжүүлж, эрсдэлийн удирдлагын аргачлалыг урьдчилан сэргийлэх зорилгоор идэвхтэй ашиглахыг дэмжих. ORG.19 – SEI.29 | Улсын хэмжээнд аюулгүй байдлын эрсдэлийн удирдлагыг хөгжүүлэх, дэвшилтэт түвшинд хүргэх.

---o0o---

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
26

ИРГЭНИЙ НИСЭХИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

I. УЛСЫН ХЭМЖЭЭНД НИСЛЭГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ӨНДӨР ЭРСДЭЛИЙГ ТОГТВОРТОЙГООР БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР */OPERATIONAL SAFETY RISKS (OPS) ROADMAP/:*

NASP | Зорилго 1	**Монгол Улсын хэмжээнд нислэгийн үйл ажиллагааны аюулгүй байдлын өндөр эрсдэлийг тогтвортойгоор бууруулах.**
NASP | Зорилт 1.1	**2026-2028 онд хүний амь нас эрсэдсэн агаарын хөлгийн осол гаргахгүй байх.**
NASP | Зорилт 1.2	**2026-2028 онд агаарын хөлгийн ослоос шалтгаалан агаарын хөлгийн бүтцэд гэмтэл учруулах тохиолдол гаргахгүй байх.**
NASP | Зорилт 1.3	**2028 он гэхэд ноцтой зөрчлийн тоог 50%-иар бууруулах.**
Нислэгийн үйл ажиллагааны эрсдэлүүд */Operational safety risks/*: 1. N-HRC 1: Хяналттай нислэг газрын гадаргууг мөргөх *(Controlled Flight into Terrain – CFIT);* 2. N-HRC 2: Нислэгийн үеэр удирдлагын жолоо алдагдах *(Loss of Control – In Flight - LOC-I)*; 3. N-HRC 3: Агаарын хөлгүүд агаарт мөргөлдөх *(Mid-Air Collision – MAC)*; 4. N-HRC 4: Хөөрч, буух зурвасаас гарах *(Runway Excursion – RE)*; 5. N-HRC 5: Хөөрч, буух зурвас руу зөвшөөрөлгүй нэвтрэх *(Runway Incursion – RI)*; 6. N-HRC 6: Аэродром дээр болон аэродромын орчинд зэрлэг амьтан, шувуутай мөргөлдөх *(Wildlife Strike – WS)*; 7. N-HRC 7: Агаарын хөлгийн хөөрч, буух зурвас дахь хэвийн бус буулт - Агаарын хөлөг хатуу буух, агаарын хөлөг сүүл хэсгээрээ газарт хүрэх *(Abnormal Runway Contact - ARC, including Hard Landing and Tail Strike Landing)*; 8. N-HRC 8: Нислэгийн үед агаарын хөлөг сэгсрэлтэнд орох *(Turbulence encounter – TURB)*; 9. N-HRC 9: Хүчний төхөөрөмжөөс бусад систем, эд ангийн дутагдал, эсхүл эвдрэл (System/component failure or malfunction *(non-powerplant – SCF-NP)*; 10. N-HRC 10: Хүчний төхөөрөмжийн систем, эд ангийн дутагдал, эсхүл эвдрэл (System/component failure or malfunction *(powerplant – SCF-PP)*.	
Зорилго 1 | Зорилт 1.1-1.3-ыг хэрэгжүүлэх зорилгоор дараах аюулгүй байдлыг сайжруулах дараах арга хэмжээ (SEIs)-г авч хэрэгжүүлнэ.	
OPS.1 - SEI 1. CFIT эрсдэлд хүргэх хүчин зүйлийг багасгах.	
OPS.2 - SEI 2. LOC-I эрсдэлд хүргэх хүчин зүйлийг багасгах.	
OPS.3 - SEI 3. MAC эрсдэлд хүргэх хүчин зүйлийг багасгах.	
OPS.4 - SEI 4. RE эрсдэлд хүргэх хүчин зүйлийг багасгах.	
OPS.5 - SEI 5. RI эрсдэлд хүргэх хүчин зүйлийг багасгах.	
OPS.6 - SEI 6. WS эрсдэлд хүргэх хүчин зүйлийг багасгах.	

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сайд Нарийн бичгийн хэлтсийн
дарын 26 оны А/53 дугаар тушаал

OPS.7 - SEI 7. ARC эрсдэлд хүргэх хүчин зүйлийг багасгах.
OPS.8 - SEI 8. TURB эрсдэлд хүргэх хүчин зүйлийг багасгах.
OPS.9 - SEI 9. SCF-NP эрсдэлд хүргэх хүчин зүйлийг багасгах.
OPS.10 - SEI 10. SCF-PP эрсдэлд хүргэх хүчин зүйлийг багасгах.

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ

OPS.1 – SEI.1 | N-HRC 1: Хяналттай нислэг газрын гадаргууг мөргөх *(Controlled Flight into Terrain – CFIT)*

NASP | Зорилго 1: Монгол Улсын хэмжээнд нислэгийн үйл ажиллагааны аюулгүй байдлын өндөр эрсдэлийг тогтвортойгоор бууруулах.						
Зорилт 1.1. 2026-2028 онд хүний амь нас эрсэдсэн агаарын хөлгийн осол гаргахгүй байх. Зорилт 1.2. 2026-2028 онд агаарын хөлгийн ослоос шалтгаалан агаарын хөлгийн бүтцэд гэмтэл учруулах тохиолдол гаргахгүй байх. Зорилт 1.3. 2028 он гэхэд ноцтой зөрчлийн тоог 50%-иар бууруулах.						
GASP SEI	National SEI	Аюулгүй байдлын сайжруулах арга хэмжээ	Хэрэгжүүлэх нэгж	Хугацаа	Хэмжих үзүүлэлт	Хяналт
OPS 1 - SEI 1 CFIT эрсдэлд хүргэх хүчин зүйлийг багасгах. */Mitigate contributing factors to the risk of CFIT/*	OPS 1 - SEI 1 CFIT эрсдэлд хүргэх хүчин зүйлийг багасгах. */Mitigate contributing factors to the risk of CFIT/*	1. CFIT-ээс сэргийлэх дараах арга хэмжээг авах. */Implement the following CFIT safety actions/:* 1.1. Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенцын "Хавсралт 6. Нислэгийн үйл ажиллагааны стандарт"-д нийцүүлэн агаарын хөлөг газрын гадаргууг мэдэрч анхааруулах систем (terrain awareness and warning system - TAWS)-ээр тоноглогдсон байх шаардлагатай холбоотой эрх зүйн зохицуулалтыг баталгаажуулах. */Ensure aircraft are equipped with terrain awareness and warning system (TAWS) in accordance with Annex 6 – Operation of Aircraft./*	ИНЕГ	2026 оноос эхлэн тогтмол хэрэгжүүлэх	- Жил бүрийн CFIT тохиолдлын тоо */Number of CFIT accident, incident per year/* - Жил бүрийн TAWS анхааруулга ажилласан тохиолдлын тоо */Number of TAWS triggers per year/*	Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигчид болон агаарын навигацийн үйлчилгээний байгууллагын үйл ажиллагаанд хийх хяналт шалгалтаар баталгаажуулах */surveillance of AOCs and ANSP activities/*
		1.2. "Хавсралт 6. Нислэгийн үйл ажиллагааны стандарт"-ын шаардлагаас гадна TAWS-ын хэрэглээг өргөжүүлэх, дэмжих зохицуулалтыг эрх зүйн баримт бичигт тусгах. */Promote the wider use of TAWS beyond the requirements of Annex 6./*				
		1.3. TAWS дохиолол ажилласан үед стандарт үйл ажиллагааны журам (SOP)-ыг дагаж мөрдөх нийцлийг нэмэгдүүлэхийн тулд аюулгүй байдлын зөвлөмж гаргах. */Issue a Safety Advisory to increase adherence to TAWS warning procedures./*				

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сайд Төрийн нарийн бичгийн
дэвлэл 26 он А/93 дугаар тушаал

		1.4. Ойртолтын нислэгийн аюулгүй байдлын эрсдэлүүдийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэхийг дэмжих. */Promote greater awareness of approach risks/*: - Ойртолтын нислэгийн үед тогтмол өндөр алдах нислэгийн горимыг (continuous descent final approaches) мөрдөх */Consider the implementation of continuous descent final approaches (CDFA)/*; - Минимум аюулгүй өндрийн түвшнийг анхааруулах систем (Minimum safe altitude warning system - MSAW)-ийг ашиглах */Consider the implementation of minimum safe altitude warning (MSAW) systems/*; - Газрын гадаргуу, газрын саадын электрон өгөгдөл (Electronic Terrain and Obstacle Data – eTOD) бодит цаг хугацаанд шинэчлэгдэж байгаа эсэхийг бататгах */Ensure the timeliness of updates and accuracy of Electronic Terrain and Obstacle Data (eTOD)/*; - TAWS-д өгөгдөл дамжуулахад GPS-аас гаргасан байршлын өгөгдлийг ашиглах */Promote the use of GPS-derived position data to feed TAWS/*.				
		2. CFIT-ээс сэргийлэх дээрх арга хэмжээний хэрэгжилтийг аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны аргачлалаар заавал болон сайн дураар мэдээлэх систем болон осол, зөрчлийн шинжлэн шалгалтын дүн шинжилгээнд үндэслэн үнэлэх. */Validate the effectiveness of the safety enhancement initiatives (SEIs) presented*	- АХОЗШША - ИНЕГ	2026 оноос эхлэн тогтмол хэрэгжүүлэх	- Жил бүрийн CFIT тохиолдлын тоо */Number of CFIT accident, incident per year/* - Жил бүрийн TAWS анхааруулга ажилласан	Аюулгүй байдлын дүн шинжилгээ */safety trend analysis/*

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ

		in this roadmap through the analysis of mandatory occurrence reporting (MORs) and voluntary occurrence reporting systems (VORs) and accident/incident investigations (apply safety management methodologies)/			тохиолдлын тоо */Number of TAWS triggers per year/*	
		3. Нэмэлт CFIT үүсэх хүчин зүйлсийг тодорхойлох. Жишээ нь: - Байгаль, цаг уурын таагүй нөхцөлд нислэг үйлдэх; - Хэрэглэлийн нислэгийн журам болон заавар (Босоо тэнхлэгийн чиглүүлэгчтэй ойртолтын журам /approaches with vertical guidance – AVP/ эсхүл Босоо тэнхлэгийн чиглүүлэгчийн локалайзерийн үзүүлэлт /Localizer performance with vertical guidance - LPV/); - Загварчилсан хэллэгийн ашиглалт (стандарт ба стандарт бус); - Нисгэгч ядаргаанд орох, зүг чигээ алдах. */Identify additional contributing factors, for example:* *a) Flight in adverse environmental conditions;* *b) Approach design and documentation (e.g. approaches with vertical guidance (APV) or localizer performance with vertical guidance (LPV) approaches);* *c) Phraseology used (standard vs. non standard);* *d) Pilot fatigue and disorientation./*	- АХОЗШША - ИНЕГ - Аэродром, нисэх буудлын үйлчилгээний байгууллага - Агаарын тээвэрлэгч - Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллага	2026 оноос эхлэн тогтмол хэрэгжүүлэх	-	Дүн шинжилгээ */safety analysis/*
		4. CFIT үүсэх хүчин зүйлсийн эрсдэлийг бууруулах зорилгоор нэмэлт аюулгүй байдлыг сайжруулах арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэх. */Develop and implement further SEIs to mitigate the risk of the identified contributing factors, if any, for CFIT/*	- АХОЗШША - ИНЕГ	2026 оноос эхлэн тогтмол хэрэгжүүлэх	-	Дүн шинжилгээ */safety analysis/*
		5. CFIT-ээс сэргийлэх дараах арга	- Агаарын	2026 оноос	-	-

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
26 А/93

		хэмжээг авах */Implement the following CFIT safety actions/:* 5.1. Агаарын хөлгийг TAWS системээр тоноглох. */Equip aircraft with TAWS/*	тээвэрлэгч - Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллага	эхлэн тогтмол хэрэгжүүлэх		
		5.2. TAWS анхааруулах журмыг мөрдөхийг нэмэгдүүлэх. */Increase adherence to TAWS warning procedures/*	- Агаарын тээвэрлэгч - Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллага	2026 оноос эхлэн тогтмол хэрэгжүүлэх		
		5.3. Ойртолтын нислэгийн аюулгүй байдлын эрсдэлүүдийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх. */Develop greater awareness of approach risks/*	- Агаарын тээвэрлэгч - Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллага	2026 оноос эхлэн тогтмол хэрэгжүүлэх		
		5.4. Ойртолтын нислэгийн үед тасралтгүй өндөр алдах нислэгийн горимыг (continuous descent final approaches) таниулах. */Promote CDFA/*	- Агаарын тээвэрлэгч - Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллага	2026 оноос эхлэн тогтмол хэрэгжүүлэх		
		5.5. MSAW системийг ашиглах. */Utilize MSAW systems/*	- Агаарын навигацийн үйлчилгээний байгууллага	2026 оноос эхлэн тогтмол хэрэгжүүлэх		
		5.6. Бодит цаг хугацаанд шинэчлэгдэж байгаа газрын гадаргуу, газрын саадын электрон өгөгдөл (Electronic Terrain and Obstacle Data – eTOD)-ийг ашиглах. */Utilize up-to- date TOD/*	- Агаарын тээвэрлэгч - Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллага	2026 оноос эхлэн тогтмол хэрэгжүүлэх		
		6. Аюулгүй байдлын сайжруулах арга хэмжээ OPS 1 - SEI 1-ийн хэрэгжилтийг тогтмол үнэлэх. */Conduct continuous evaluations of the performance of the SEI/*	Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөл	2026 оноос эхлэн тогтмол хэрэгжүүлэх	Жил бүрийн CFIT зөрчлийн тоо */Number of CFIT incidents per year/*	Жил бүрийн NASP-ын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх */annual NASP review/*

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сайд, Төрийн нарийн бичгийн
дарга 26 А/53 гэрчилсэн гэдэг

OPS.2 – SEI.2 | N-HRC 2: Нислэгийн үеэр удирдлагын жолоо алдагдах (Loss of control - In Flight - LOC-I)

NASP | Зорилго 1: Монгол Улсын хэмжээнд нислэгийн үйл ажиллагааны аюулгүй байдлын өндөр эрсдэлийг тогтвортойгоор бууруулах. Зорилт 1.1. 2026-2028 онд хүний амь нас эрсэдсэн агаарын хөлгийн осол гаргахгүй байх. Зорилт 1.2. 2026-2028 онд агаарын хөлгийн ослоос шалтгаалан агаарын хөлгийн бүтцэд гэмтэл учруулах тохиолдол гаргахгүй байх. Зорилт 1.3. 2028 он гэхэд ноцтой зөрчлийн тоог 50%-иар бууруулах.						
GASP SEI	National SEI	Арга хэмжээ	Хэрэгжүүлэх нэгж	Хугацаа	Хэмжих үзүүлэлт	Хяналт
OPS 2 - SEI 2 LOC-I эрсдэлд хүргэх хүчин зүйлийг багасгах. */Mitigate contributing factors to the risk of LOC-I/*	OPS 2 - SEI 2 LOC-I эрсдэлд хүргэх хүчин зүйлийг багасгах. */Mitigate contributing factors to the risk of LOC-I/*	1. Нислэгийн үеэр удирдлагын жолоо алдагдах (Loss of control - In Flight – LOC-I)-ээс сэргийлэх дараах арга хэмжээг ИНЕГ-аас авах */Implement the following LOC-I safety actions/:* 1.1. Симулятор дээр явагдах сургалтын хөтөлбөрүүдэд агаарын хөлөг уруу харахаас сэргийлэх болон уруу харвал хэвийн байдалд буцаан оруулах сургалтыг шаардах; */a) Require upset prevention and recovery training in all full flight simulator type conversion and recurrent training programmes/*	ИНЕГ	2026 оноос эхлэн тогтмол хэрэгжүүлэх	Батлагдсан сургалтын хөтөлбөр */Approved Technical Guidance Material to the industry/*	Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигчийн сургалтын хөтөлбөрт хийх хяналт шалгалт */Surveillance of AOCs Training programmes/*
		1.2. Ажиглагч нисгэгчийн үүрэгт зориулсан сургалтыг үр дүнтэй болгоход илүү цаг зарцуулахыг шаардсан байх. */b) Require more time devoted to training for the pilot monitoring role/*				
		2. LOC-I-ээс сэргийлэх дээрх арга хэмжээний хэрэгжилтийг аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны аргачлалаар заавал болон сайн дураар мэдээлэх систем болон осол, зөрчлийн шинжлэн шалгалтын дүн шинжилгээнд үндэслэн үнэлэх. */Validate the effectiveness of the safety enhancement initiatives (SEIs) presented in this roadmap through the analysis of mandatory occurrence reporting (MORs) and voluntary occurrence reporting*	ИНЕГ	2026 оноос эхлэн тогтмол хэрэгжүүлэх	- Жил бүрийн LOC-I зөрчлийн тоо */Number of LOC-I incidents per year/*	Аюулгүй байдлын дүн шинжилгээний жилийн тайлан */Safety annual review/*

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
26 №93

		systems (VORs) and accident/incident investigations (apply safety management methodologies)/				
		3. Нэмэлт LOC-I үүсэх хүчин зүйлсийг тодорхойлох. Жишээ нь: - Анхаарал сарних; - Цаг уурын таагүй нөхцөл; - Хэт тайвшрах /Анхаарал сулрах/; - Нислэгийг үр дүнтэй удирдахтай холбоотой стандарт ажиллагааны журам (SOP)-ын хангалтгүй байдал; - Газрын гадаргууд ойртсноос өндөр авах боломжгүй байх; - Агаарын хөлгийг хэвийн бус байрлалаас сэргээх журмын талаар мэдлэг, туршлага хангалтгүй байх; - Хазайлтын өнцөг хэтэрснийг гэнэт мэдэрсний улмаас тохиромжгүй удирдлагын оролт хийх. */Identify additional contributing factors, for example:* *a) Distraction;* *b) Adverse weather;* *c) Complacency;* *d) Inadequate standard operating procedures (SOPs) for effective flight management;* *e) Insuffcient height above terrain for recovery;* *f) Lack of awareness of or competence in procedures for recovery from unusual aircraft attitudes;* *g) Inappropriate flight control inputs in response to a sudden awareness of an abnormal bank angle./*	- ИНЕГ - Салбарын хэмжээнд	2026 оноос эхлэн тогтмол хэрэгжүүлэх	- Жил бүрийн LOC-I зөрчлийн тоо */Number of LOC-I incidents per year/*	Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигчийн сургалтын хөтөлбөр болон сургалтын үед хяналт шалгалт хийх */Surveillance of AOCs Training programmes, conduct enroute inspection/*
		4. LOC-I үүсэх хүчин зүйлсийн эрсдэлийг бууруулах зорилгоор нэмэлт аюулгүй байдлыг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх: - ИНЕГ-ын хяналт шалгалтын үр нөлөөг нэмэгдүүлэх;	- ИНЕГ - Салбарын хэмжээнд	2026 оноос эхлэн тогтмол хэрэгжүүлэх	- Жил бүрийн LOC-I зөрчлийн тоо */Number of LOC-I incidents per year/*	Хяналт шалгалт */Surveillance/*

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сайд, Төрийн нарийн бичгийн
дарга 26 А/55 гүйцэтгэх үүрэг

		- Холбогдох дүрмийн зохицуулалтыг сайжруулах. */Develop and implement further SEIs to mitigate the risk of the identified contributing factors, if any, for LOC-I, for example:* *a) Increase the effectiveness of regulatory oversight;* *b) Improve regulations./*				
		5. Нислэгийн үеэр удирдлагын жолоо алдагдах (Loss of control - In Flight – LOC-I)-ээс сэргийлэх дараах арга хэмжээг агаарын тээвэрлэгчид авах */Implement the following LOC-I safety actions/:* - Симулятор дээр явагдах сургалтын хөтөлбөрүүдэд агаарын хөлөг уруу харахаас сэргийлэх болон уруу харвал хэвийн байдалд буцаан оруулах сургалтыг шаардах; - Олон нисгэгчтэй нислэгт хяналтын үүрэг гүйцэтгэх үүрэг гүйцэтгэх ур чадварыг хөгжүүлэх сургалтад илүү их хугацаа зориулах; - Өргөх хүч үүсэхээ болихоос өмнөх болон өргөх хүч үүсэхээ блоих үед агаарын хөлгийг гараар удирдах, нөхөн сэргээх ур чадвартай холбоотой сургалтыг /өндрийн нөхцөл багтана/ явуулах; - Нислэгийн үндсэн зарчмуудын тухай давтан сургалт явуулах; - Симуляторын бодит нөхцөлд ойртсон түвшин (fidelity)-ийг хангах. */a) Aircraft upset prevention recovery training in all full flight simulator type conversion and recurrent training programmes;* *b) More time devoted to training multicrew pilots for the monitoring role;*	Салбарын хэмжээнд	2026 оноос эхлэн тогтмол хэрэгжүүлэх	- Жил бүрийн LOC-I зөрчлийн тоо */Number of LOC-I incidents per year/*	- Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч сургалтын хөтөлбөрт дотоод аудит хийх */Internal audit of operator – Training programme/* - Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигчийн сургалтын хөтөлбөрт хийх хяналт шалгалт, гэрчилгээжүүлэлт */Certification and Surveillance of AOCs Training programmes/* - Нислэгийн симулятор сургалтын төхөөрөмжүүдэд хийх үзлэг, хяналт шалгалт */Inspections and surveillance of*

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
26 ЯЯЗ

		c) Training on manual aircraft handling of approach to stall and stall recovery (including at high altitude); *d) Recurrent training on principles of flight;* *e) Simulator fidelity/.*				*FSTDs/*
		6. Аюулгүй байдлыг сайжруулах арга хэмжээ OPS 2 - SEI 2-ын хэрэгжилтийг тогтмол үнэлэх. */Conduct continuous evaluations of the performance of the SEI/*	Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөл	2026 оноос эхлэн тогтмол хэрэгжүүлэх	- Жил бүрийн LOC-I зөрчлийн тоо */Number of LOC-I incidents per year/*	Жил бүрийн NASP-ын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх */annual NASP review/*

МОНГОЛ УЛСЫН
ЭЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сайд Төрийн захирах бичгийн
дагуу 26 оны A/93 дугаар тушаал

OPS.3 – SEI.3 | N-HRC 3: агаарын хөлгүүд агаарт мөргөлдөх (Mid-air collision - MAC)

NASP | Зорилго 1: Монгол Улсын хэмжээнд нислэгийн үйл ажиллагааны аюулгүй байдлын өндөр эрсдэлийг тогтвортойгоор бууруулах. Зорилт 1.1. 2026-2028 онд хүний амь нас эрсэдсэн агаарын хөлгийн осол гаргахгүй байх. Зорилт 1.2. 2026-2028 онд агаарын хөлгийн ослоос шалтгаалан агаарын хөлгийн бүтцэд гэмтэл учруулах тохиолдол гаргахгүй байх. Зорилт 1.3. 2028 он гэхэд ноцтой зөрчлийн тоог 50%-иар бууруулах.						
GASP SEI	National SEI	Арга хэмжээ /Actions/	Хэрэгжүүлэх нэгж	Хугацаа	Хэмжих үзүүлэлт	Хяналт
